# ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ

2023 оны 06 сарын 19 өдөр Есөнзүйл сум

| № | Холбогдох эрхзүйн акт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Он, сар, өдөр | Дугаар | Хяналтанд авсан заалтын | | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжилтийн явц /хувь/ |
| | | | Д/д | Дугаар | | |
| | **Нэг. Монгол улсын хууль** | | | | | |
| 1 | 2021.12.27 | | 1 | - | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 2 | 2021.07.02 | | 2 | - | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 3 | 2021.07.02 | | 3 | - | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 4 | 2017.12.07 | | 4 | - | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 5 | 2011.12.23 | | 5 | - | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 6 | 2011.05.05 | | 6 | - | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 7 | 2002.05.03 | | 7 | - | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| **Хэрэгжилтийн дундаж 100 хувь.** | | | | | | |
| | **Хоёр. Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |
| 8 | 2019.02.01 | 21 | 8 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 9 | 2016.11.03 | 51 | 9 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| **Хэрэгжилтийн дундаж 100 хувь.** | | | | | | |
| | **Гурав. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |
| 10 | 2021.09.30 | 03 | 10 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 11 | 2010.04.14 | 63 | 11 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| **Хэрэгжилтийн дундаж 100 хувь.** | | | | | | |
| | **Дөрөв. Засгийн Газрын тогтоол** | | | | | |
| 12 | 2023.05.17 | 185 | 12 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 13 | 2023.04.05 | 119 | 13 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 14 | 2023.01.05 | 11 | 14 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 15 | 2022.11.02 | 392 | 15 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 16 | 2022.08.24 | 314 | 16 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 17 | 2022.03.16 | 118 | 17 | 5 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 18 | 2022.03.02 | 92 | 18 | 1 | | Хэрэгжих шатандаа 30% |
| 19 | 2022.02.23 | 81 | 19 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 20 | 2022.01.05 | 07 | 20 | 5 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 21 | 2021.12.01 | 359 | 21 | 4 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 22 | 2021.08.11 | 237 | 22 | 4 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 23 | 2021.06.23 | 173 | 23 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 24 | 2021.03.10 | 58 | 24 | 3 | | - |
| 25 | 2021.03.17 | 67 | 25 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 26 | 2021.02.24 | 47 | 26 | 3 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 27 | 2021.01.20 | 18 | 27 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 28 | 2021.02.17 | 43 | 28 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 29 | 2021.02.10 | 29 | 29 | 4 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 30 | 2020.05.06 | 163 | 30 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 31 | 2020.03.25 | 113 | 31 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 32 | 2020.03.25 | 106 | 32 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 33 | 2 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 33 | 2020.03.18 | 96 | 34 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 34 | 2020.02.28 | 78 | 35 | 8 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 35 | 2020.01.29 | 34 | 36 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 36 | 2019.05.01 | 185 | 37 | 4 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 37 | 2019.03.21 | 111 | 38 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 38 | 2019.01.09 | 9 | 39 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 39 | 2019.01.09 | 7 | 40 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 40 | 2019.01.09 | 6 | 41 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 41 | 2019.01.03 | 57 | 42 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 42 | 2018.08.22 | 258 | 43 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | | | 44 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 45 | 3 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | | | 46 | 4 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | | | 47 | 6 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | | | 48 | 7 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | | | 49 | 10 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 43 | 2018.06.20 | 189 | 50 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 44 | 2018.05.23 | 138 | 51 | 2 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 45 | 2018.04.06 | 68 | 52 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 46 | 2018.02.14 | 50 | 53 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 47 | 2018.01.24 | 20 | 54 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 48 | 2018.01.03 | 04 | 55 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 49 | 2017.12.13 | 340 | 56 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 50 | 2017.03.20 | 98 | 57 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 51 | 2017.02.01 | 46 | 58 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 52 | 2017.01.02 | 31 | 59 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 53 | 2016.01.04 | 15 | 60 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 54 | 2015.08.31 | 353 | 61 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 55 | 2013.03.22 | 106 | 62 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 56 | 2011.11.09 | 311 | 63 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 57 | 2009.05.14 | 143 | 64 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 58 | 2009.04.01 | 93 | 65 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 66 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 67 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 68 | 4 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 69 | 5 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 59 | 2006.08.16 | 19 | 70 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 60 | 2005.04.01 | 67 | 71 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 61 | 2005.03.09 | 44 | 72 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| **Хэрэгжилтийн дундаж 91,3 хувь.** | | | | | | |
| | **Тав. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 62 | 2022.02.09 | 99 | 73 | 5 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 63 | 2022.03.16 | 16 | 74 | 1 | | - |
| 64 | 2021.08.31 | 49 | 75 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| **Хэрэгжилтийн дундаж 85 хувь.** | | | | | | |
| | **Зургаа. Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 65 | 2017.10.26 | 01 | 76 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 77 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 78 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 79 | 4 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | | | 80 | 5 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 81 | 6 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 82 | 7 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 83 | 8 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | | | 84 | 10 | | Хэрэгжих шатандаа 70% |
| | | | 85 | 11 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| | | | 86 | 12 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| **Хэрэгжилтийн дундаж 91,8 хувь.** | | | | | | |

| |
|---|
| **Нийт дундаж 94,6 хувь.** |

ХЯНАСАН:ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ОРЛОГЧ
ДАРГА Ч.ГАНХҮҮ

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ

# ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2023 оны 06 сарын 19 өдөр Есөнзүйл сум

Тус сум нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар Монгол улсын хууль 7, Ерөнхийлөгчийн зарлиг 2, Улсын Их хурлын тогтоол 2, Монгол улсын Засгийн газрын тогтоол 61, Засгийн газрын албан даалгавар 1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 3, нийтдээ 76 тогтоол шийдвэрийг хяналтандаа авч хувийн хэргийг нээн эзэнжүүлж холбогдох албан тушаалтанд танилцуулан биелэлтийг хангаж ажиллаж байна.

Тогтоол шийдвэрийн биелэлтийг тооцон гаргахад Монгол улсын 100%-ийн биелэлттэй, Монгол улсын Улсын Их хурлын тогтоол 100%-ийн биелэлттэй, Ерөнхийлөгчийн зарилга 100%-ийн биелэлттэй, Монгол улсын Засгийн газрын тогтоол 91,3%-ийн биелэлттэй, Монгол улсын Засгийн газрын албан даалгавар 91,8%-ийн биелэлттэй, Монгол улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 84%-ийн биелэлттэй биелэлттэй байна.

**Тогтоолын биелэлтийг хангаж ажилласны үр дүнд:**

**Монгол улсын хууль:** Хөдөлмөрийн тухай хуулийг төрийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн тухай хуульд нийцэж гарсан Засгийн газрын тогтоол, төрийн албаны зөвлөлийн тогтоол зэрэг холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чиглэл болгон ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулиас хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, төрийн албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэх, ажилтан болон ажил олгогчийн эрх үүргүүдийг байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үр дүнг тооцон ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн албан байгууллага тус бүр дотоод журмыг шинэчлэн болон шинээр боловсруулан мөрдөн ажиллаж байна.

**Монгол улсын Улсын Их Хурлын тогтоол:** Жил бүрийн төсөвт төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг тусган хууль тогтоомжийн дагуу зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна. Мөн 2023 оны хагас жилийн байдлаар 1 жинхэнэ албан хаагчийн материалыг зэрэг дэв ахиулахаар хүргүүлэн ажилласан байна. Хагас жилийн байдлаар зэрэг дэвийн нэмэгдлийг 2 жинхэнэ албан хаагч авч ажиллаж байна. Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг жил бүр тооцон төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцон ажилласны үр дүнд авлига, ашиг сонирхлын зөрчил дутагдал илрээгүй байна.

**Ерөнхийлөгчийн зарлиг:** "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд засмал зам дагуу 10 га газарт улиас, хайлаас, бургас төрлийн 20000 мод, бут тарьсан тарьлаа. Мөн Дөлгөөн уулын гацааны аманд 50ш улиасыг хашаалж тарих ажлыг зохион байгууллаа. Сумын төвийн хойд талд хашаалсан талбайд 2000

бургас, хайлаас, улиасны төрлийн модыг тарьлаа. Аж ахуй нэгж албан байгууллага 1200 ширхэг модыг өөрсдийн албан байгууллагын талбайг хашаажуулан хамгаалалт хийн тарьлаа. Бүх нийтээр мод тарих хөдөлгөөнийг зохион байгуулж сумыньөвийн албан байгууллага, аж ахуй нэгж, иргэд нийт 2500 модыг сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд тарих ажлыг хийж гүйцэтгэлээ. Нийтээр мод тарих өдрүүдэд 2022 болон урд жилүүдэд тарьсан мод бутыг услах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

**Засгийн газрын тогтоол:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2023 оныг "ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЖИЛ" болгон зарласантай холбоотойгоор сумын хэмжээнд төлөвлгөөө батлуулж ажлын хэсэг байгуулан 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зорилтод жилийн нээлтийн арга хэмжээг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Мөн Шинээр газар тариалан эрхэлж буй 106 өрх үүсч судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүллээ. Өрхийн хүрээнд төмс тариаллах газар хаглуулсан нийт 55 өрхөд төмсний үрийг газрын хэмжээгээс нь хамааран үнэгүй олгож ажиллалаа. Мөн иргэдийн захиалгаар ирсэн нарийн ногоо болон бусад хүнсний ногооны үрийг захиалгын дагуу иргэдэд хүргэн бүртгэл хийж ажиллалаа. Мөн зорилтод жилийн хүрээнд албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн төмс тариаллах нөхцөлийг нь ханган газар хувиарлан нэгдсэн нэг иргэнээр хагалуулан төмсний үрийг хувиарын дагуу олгож ажиллалаа.

Сум хөгжүүлэх санг Хоршоо хөгжүүлэх сан болгон өөрчилж үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан "Сум хөгжүүлэх сан"-ийн программын нэр Төрийн сан дахь сум хөгжүүлэх сангийн дансны нэрийг Хоршоо хөгжүүлэх сан болгон өөрчлөөд байна. Сангаас зээл авсан иргэдэд дансны нэрийг зөв бичихийг анхааруулан ажиллаж байна. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 2023 оны 2-р улирлын байдлаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 50.002.186, зээлдэгчийн тоо 31 иргэн аж ахуйн нэгж байгаагаас 215,358,906.25 зээлийн үлдэгдэлтэй байна. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар баталсан " Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам "-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээж авах үйл ажиллагааны зарыг орон нутгийн мэдээллийн сайтуудад байршуулан 3 аж ахуйн нэгж, 1 хоршоо, 8 иргэнд нийт 170,300,000 төгрөгний зээлийг 2022 оны 12 дугаар сард олгоод байна.

Есөнзүйл суманд 2023 оны 02 дугаар улирлын байдлаар нийт 161 өргөдөл хүлээж авсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 305 өргөдөл хүлээн авч бүх өргөдлийг 100% шийдвэрлэж ажилласан байна. Ирүүлсэн нийт өргөдлүүд 100% бичгээр ирсэн бөгөөд бүртгэл хяналтын карт үүсгэн шийдвэрлэх ёстой хугацаанд нь шийдвэрлэж ажилласан байна. Ирсэн өргөдлөөс нийгмийн халамжтай өргөдөл хамгийн өндөр хувийг эзэлж байна. Байгууллагын үйл ажиллагаатай болон материал мөнгөн тусламж хүссэн өргөдөл ирээгүй байна. Байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг бэлтгэсэн маягтын дагуу цахим болон цаасаар баталгаажуулан авч ажиллаж байна. Албан байгууллага болон өргөдөл гомдол хүлээн авч буй албан хаагчдад "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн дагуу өргөдөл хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөөг өгөн ажиллаж байна.

Суманд хэрэгжиж буй тогтоол шийдвэрийн тайланг жил бүр Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаж хэвшээд байна.

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ОРЛОГЧ
ДАРГА Ч.ГАНХҮҮ

ТАЙЛАН БИЧСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ

ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ШИЙДВЭРИЙН
2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2023 оны 06 сарын 19 өдөр — Есөнзүйл сум

| № | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Биелэлт | Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Нэг.Монгол улсын хууль** | | | | | |
| 1 | 1 | Хөдөлмөрийн тухай хууль 2021.07.02 | Хөдөлмөрийн тухай хуулийг төрийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн тухай хуульд нийцэж гарсан Засгийн газрын тогтоол, төрийн албаны зөвлөлийн тогтоол зэрэг холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чиглэл болгон ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулиас хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, төрийн албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэх, ажилтан болон ажил олгогчийн эрх үүргүүдийг байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үр дүнг тооцон ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн албан байгууллага тус бүр дотоод журмыг шинэчлэн болон шинээр боловсруулан мөрдөн ажиллаж байна. | 100 | |
| 2 | 2 | Төрийн албаны тухай хууль 2017.12.07 | Төрийн албаны тухай хуулийг төрийн байгууллагууд албан хаагчдын ёс зүйнг сахиулах, төрийн албан хаагчийн үүрэг хариуцлагыг сахиулахад мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн төрийн албаны тухай хуульнд заасан төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагчийн бүрэн эрхийг тэдгээрийн тушаал шийдвэрт үндэслэл болгон өдөр тутамдаа хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалт хөгжил, цалин хөлс олголтын | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | талаарх зүйл заалтыг хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллаж байна. | | |
| 3 | 3 | Төсвийн тухай хууль 2011.12.23 | Сумын төрийн байгууллагууд төсвийн тухай хуулийн төсвийн ерөнхийлөн захирагч, тусвийн шууд захирагчийн бүрэн эрх бүхий заалтуудын өдөр тутмын шийдвэрт нь үндэслэл болгон хэрэгжүүлж байна. Мөн Төсвийн зүй зохистой зарцуулалт зүй зохистой орлого бүрдүүлэлтийн талаарх зүйл заалтыг мөрдлөгө болгон хэрэгжүүлж ажиллаж байна. | 100 | |
| 4 | 4 | Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05 | "Эрүүл мэндийн тухай хуулийн" 21 дугаар зүйлийн 21.3.1, 21.3.2, 21.3.3, 21.3.4, 29 дүгээр зүйлийн 29.7, 42 дугаар зүйлийн 42.1, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан 2015 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 329 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/41 тушаал, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12-р сарын 28-ны өдрийн "Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол, унааны хөнгөлөлт нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 сарын 30-ны 537 дугаар тушаал, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 116, А/565 дугаар тушаалуудыг тус тус 2023 оны эхний хагас жил мөрдөж ажилласан байна. | 100 | |
| 5 | 5 | Соёлын тухай хууль 2021.07.02 | Соёлын бодлого, үйл ажиллагаанд баримтлах зүйл заалтыг хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн 2023 оны эхний хагас жилийн хувьд Соёлын тухай хуулийн 33 дугаар зүйл зааснаар соёлын байгууллагад сүүлийн 5 жил тасралгүй ажилласан албан хаагчдад 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгоно гэсний дагуу Соёлын төвийн эрхлэгч, Бүжгийн багш, Номын санч нарт 5 жилийн тэтгэмжийг олгож ажиллаад байна. | 100 | |
| 6 | 6 | Боловсролын тухай хууль 2002.05.03 | Боловсролын тухай хуулийг сургалтын үйл ажиллагаа болон багш ачилчдын ажлын чиг үүрэгт тогмол мөрдүүлэн ажиллаж байна. Сурагчдад хүртээмжтэй, чанартай ,хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмшүүлэх сургалтын таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд сургалт хүмүүжлийн ажлыг амжилттай зохион байгуулж суурь боловсролыг 31 сурагч, Бүрэн дунд боловсролыг 18 сурагч эзэмшин амжилттай төгслөө.Тус хичээлийн жилд Хүүхдийн өөрөө удирдах байгууллагууд сурагчдын авьяасыг хөгжүүлэн амжилттай ажилласан.Эко клубынхэн аймгийн уралдаанд амжилттай оролцож тусгай байранд 2 удаа орсон, анги | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нийтийн массын олимпиадад анги хамт олноо амжилттай бэлтгэн "Тоо бодож оюунаа хөгжүүлье" аянд 3а анги, 8А ангиуд гутгаар зэргийн болзлыг хангалаа. Төрөлжсөн олимпиадад Биологийн хичээлээр Ч.Уламбаяр багшийн бэлтгэсэн 12а ангийн сурагч Болор-Эрдэнэ хүрэл медаль, бага ангийн багш Л.Мядагмаа математикийн олимпиадад 4-р байр эзэлсэн. ЭЕШ-д аймаг, улсын дунджаас дээгүүр монголхэл, математик, газарзүй, биологи,орос хэл, хими зэрэг хичээлүүд шалгагдлаа. | | |
| 7 | 7 | Нийтийн ил тод байдлыг тухай хууль 2021.12.27 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллэгчийн байнга ил тод байлгах мэдээллүүдийг албан хаагчид өөрсдийн албан тушаалын тодорхойлолтын чиг үүргийн хүрээнд ил тод байлгах хэрэгсээл болох албаны веб сайт, цахим хуудас, албаны сайтуудад тогтмол байршуулан ажиллаж байна. Мөн төрийн байгууллагууд жил болгоны эцэст тус хуулийн хэрэгжилтийг бүтэн жилээр тайлагнан ажиллаж байна. | 100 | |
| **Хэрэгжилтийн дундаж 100 хувь.** | | | | | |
| **Хоёр. Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |
| 8 | 8 | Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай 2019.02.01 №21<br>2.Төрийн захиргааны албан хаагчид 2019 онд олгох зэрэг дэвийн нэмэгдлийг баталсан төсвийн хэмжээнд багтаан зохицуулж, цаашид шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай. | Жил бүрийн төсөвт төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг тусган хууль тогтоомжийн дагуу зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна. Мөн 2023 оны хагас жилийн байдлаар 1 жинхэнэ албан хаагчийн материалыг зэрэг дэв ахиулахаар хүргүүлэн ажилласан байна. Хагас жилийн байдлаар зэрэг дэвийн нэмэгдлийг 2 жинхэнэ албан хаагч авч ажиллаж байна. | 100 | |
| 9 | 9 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016.11.03 №51<br>2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай. | Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг жил бүр тооцон төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцон ажилласны үр дүнд авлига, ашиг сонирхлын зөрчил дутагдал илрээгүй байна. | 100 | |
| **Хэсгийн дундаж 100 хувь.** | | | | | |
| **Гурав. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 10 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар №03<br>3.5.Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд засмал зам дагуу 10 га газарт улиас, хайлаас, бургас төрлийн 20000 мод, бут тарьсан тарьлаа. Мөн Дөлгөөн уулын гацааны аманд 50ш улиасыг хашаалж тарих ажлыг зохион байгууллаа. Сумын төвийн хойд талд хашаалсан талбайд 2000 бургас, хайлаас, улиасны төрлийн модыг тарьлаа. Аж ахуй нэгж албан байгууллага 1200 ширхэг модыг өөрсдийн албан байгууллагын талбайг хашаажуулан хамгаалалт хийн тарьлаа. | 100 | |
| 11 | 11 | Мод тарих үндэсний өдөр болгон зарлах тухай 2010.04.14 №63<br>1.Жил бүрийн 5,10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн бямба гаригийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласугай.<br>2. Мод тарих үндэсний өдөр бүх нийтээр мод, бут,сөөг, цэцэг тарих цаашид арчилан хамгаалах түүнийгээ амьдралын хэв маяг болгон сурталчилж ажиллахыг монгол улсын нийт ард иргэд, төрийн бүх байгууллага, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, хандивлагч нарт уриалсугай | Бүх нийтээр мод тарих хөдөлгөөнийг зохион байгуулж сумыньөвийн албан байгууллага, аж ахуй нэгж, иргэд нийт 2500 модыг сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд тарих ажлыг хийж гүйцэтгэлээ. Нийтээр мод тарих өдрүүдэд 2022 болон урд жилүүдэд тарьсан мод бутыг услах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100 | |
| **Хэсгийн дундаж 100 хувь.** | | | | | |
| **Дөрөв.Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 12 | 12 | Журам батлах тухай 2023.05.17 №185<br>1."Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг хавсралт ёсоор батласугай.<br><br>2.Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд тэтгэмж олгоход шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийж санхүүжүүлэх, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт үүрэг болгосугай. | Соёлын тухай хуулийн 33 дугаар зүйл болон Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Журам батлах тухай" 185 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам"-ын хэрэгжилтийг хангаж Соёлын төвийн эрхлэгч, Номын санч, Бүжгийн багш гэсэн Залбан хаагчдадхуульд заасны дагуу сүүлийн 6 сарын цалинтай тэнцэх тэтгэмжийг олгож ажиллалаа. | 100 | |
| 13 | 13 | Мөнгөн төлбөрийн хэлжээг тогтоох тухай 2023.04.05 №119 | Тус сумаас цэргийн дүйцүүлэх албанд 2023 оны хагас жилийн байдлаар цэргийн дүйцүүлэх албыг хааж буй иргэн байхгүй | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.Цэргийн дүйцүүлэх албыг 2023 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 11,935,308 (арван нэгэн сая есөн зуун гучин таван мянга гурван зуун найман) төгрөгөөр тогтоосугай.<br><br>2.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | байна. 2023 оны хагас жилийн байдлаар 20 иргэн мөнгөн төлбөрийн тооцоог хийн ажиллаж байна. | | |
| 14 | 14 | Журам батлах тухай 2023.01.05 №11<br>1."Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.<br><br>2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайханд даалгасугай. | Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг сумын 0-18 насны 920 хүүхдэд сар бүр 92,000,000 төгрөг буюу нийт 552,000,000 төгрөгийг олгоод байна. | 100 | |
| 15 | 15 | Журам батлах тухай 2022-11-02 №392<br>"Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай<br>хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам"<br>5.1.Үндэсний жагсаалтад бүртгэсэн соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах ажлыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүх шатны Засаг дарга, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулна. | 2023 оны хагас жилийн байдлаар соёлын биет бус өв шинээр бүртгэгдээгүй байгаа бөгөөд Соёлын биет бус өвийн судалгааг гарган ажиллаж байна. | 70 | |
| 16 | 16 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 №314<br>2.Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө | Ардын урлаг болох дуу, бүжгийг хүүхдүүд болон насанд хүрэгчдэд дугуйлангийн багш нар идэвхтэй хичээллэж хүүхдийн тоог нэмэгдүүлж ажиллаж байна. Бага,дунд, ахлах анги нийлсэн 30 хүүхэд бүжгийн дугуйланд хичээллэдэг.Монгол ардын бүжиг, Чөлөөт бүжиг, Бий биелгээ гэсэн 3 төрлийн бүжгийг тогтмол цагийн хуваарийн дагуу заажи сурган дугуйлангийнхаа үйл ажиллагааг явуулдаг. Соёлын төвийн эрхлэгч сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Соёлын төвийн дарга Т.Нарангэрэл уртын дууны дугуйланг тогтмол хичээллүүлж 7 хоногийн мягмар, пүрэв гаригт 2 групп нийт 8 цагийн хичээл орж байна. Соёлын төвийн дэргэдэх уртын дууны дугуйланд | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дунд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | 45 хүүхэд хамрагддаг бөгөөд хагас жилийн байдлаар улсын чанартай Баянхонгор аймагт зохион байгуулсан Уртын дууны бүсийн уралдаанд уртын дууны дугуйлангийн 5 хүүхэд оролцсоноос 1 хүүхэд тусгай байр эзэлсэн амжилттай оролцоод байна. Мөн Есөнзүйл суманд бүсийн Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын уугуул Улсын ахлах Засуул, Улсын бөх цоллооч, Ардын гэгээрлийн ажилтан, Яруу найрагч, Уртын дууч Шагдарын Чимэдравданий нэрэмжит зүүн бүсийн уртын дууны уралдаанд уртын дууны дугуйлангийн нийт 14 хүүхэд оролцсоноос 4 хүүхэд амжилттай оролцож 1,2,3,4 дүгээр байранд орж амжилтыг үзүүлээд байна. "Шатрын цодгор хүү" дугуйланд бага ангийн насны ангилалд нийт 30 гаруй сурагчид хамрагддаг бөгөөд 2023 оны 05 дугаар сард шатрын дугуйлангийн сурагчдын дунд клубын сурагчдын дунд шатрын тэмцээн 1-2-р ,3-5-р ангийн ангиллаар амжилттай зохион байгуулан 2 дахь удаагийн ээлжийн хүүхдүүдийг төгсгөөд байна. | | |
| 17 | 17 | Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-03-16 Дугаар №118<br>5.Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор иргэдийн төмс, хүнсний ногоо тариалах идэвх, санаачилгыг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх болон хүнсний ногооны тээвэрлэлт, хадгалалт, худалдааны сүлжээг хөгжүүлэх, хөдөөгийн хүн амын хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2023 оныг "ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЖИЛ" болгон зарласантай холбоотойгоор сумын хэмжээнд төлөвлөгөө батлуулж ажлын хэсэг байгуулан 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зорилтод жилийн нээлтийн арга хэмжээг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Мөн Шинээр газар тариалан эрхэлж буй 106 өрх үүсч судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүллээ. Өрхийн хүрээнд төмс тариаллах газар хаглуулсан нийт 55 өрхөд төмсний үрийг газрын хэмжээгээс нь хамааран үнэгүй олгож ажиллалаа. Мөн иргэдийн захиалгаар ирсэн нарийн ногоо болон бусад хүнсний ногооны үрийг захиалгын дагуу иргэдэд хүргэн бүртгэл хийж ажиллалаа. Мөн зорилтод жилийн хүрээнд албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн төмс тариаллах нөхцөлийг нь ханган газар хувиарлан нэгдсэн нэг иргэнээр хагалуулан төмсний үрийг хувиарын дагуу олгож ажиллалаа. | 100 | |
| 18 | 18 | Журам батлах тухай 2022-03-02 Дугаар №92<br>2. "Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>3. Удам зүйн үнэт чанарын хувьд өвөрмөц, хязгаарлагдмал нөөц, тархалт бүхий мал, амьтныг хамгаалах, зохистой үржүүлэх арга хэмжээ авч | Өвөрхангай аймгийн хөдөө аж ахуйн газар, Малын Удмын сантай хамтран нутгийн шилмэл 500 хээлтэгч малд Баянгол омгийн хээлтүүлэгчээр зохиомол хээлтүүлэг хийх ажлыг 2023 оны 10 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 30 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | | | |
| 19 | 19 | Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-02-23 Дугаар №81<br>3."Хоршооны хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Жижиг, дунд үйлдвэрийн газар (Я.Эрдэнэсайхан)-т тус тус үүрэг болгосугай. | Сум хөгжүүлэх санг Хоршоо хөгжүүлэх сан болгон өөрчилж үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан "Сум хөгжүүлэх сан"-ийн программын нэр Төрийн сан дахь сум хөгжүүлэх сангийн дансны нэрийг Хоршоо хөгжүүлэх сан болгон өөрчлөөд байна. Сангаас зээл авсан иргэдэд дансны нэрийг зөв бичихийг анхааруулан ажиллаж байна. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 2023 оны 2-р улирлын байдлаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 50.002.186, зээлдэгчийн тоо 31 иргэн аж ахуйн нэгж байгаагаас 215,358,906.25 зээлийн үлдэгдэлтэй байна. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар баталсан " **Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам** "-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээж авах үйл ажиллагааны зарыг орон нутгийн мэдээллийн сайтуудад байршуулан 3 аж ахуйн нэгж, 1 хоршоо, 8 иргэнд нийт 170,300,000 төгрөгний зээлийг 2022 оны 12 дугаар сард олгоод байна. | 100 | |
| 20 | 20 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар №7<br>5.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:<br>5.1.эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;<br>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;<br>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;<br>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга | - Улс орон даяар зохион байгуулсан Төрийн албан хаагчдын "Монголбичгийн түвшин тогтоох" судалгаанд бүрэн хамруулан ажилласан.<br>-Төрийн байгууллагад албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулах бэлтгэл хангах: 2025 онд албан бичгийг хос бичгээр хөтлөх болсонтой холбоотойгоор бэлтгэл ажлыг хангахын тулд төрийн албан хаагчдыг анхан, дунд шатны сургалтад хамруулан ажиллаж байна.<br>Нийт 110 ТАХ-ыг Монголбичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтад хамруулан,бие даан сурах боломжийг бүрдүүлсэн. Мөн төрийн албаны ерөнхий шалгалт өгөх 6 албан хаагчид Монголхэл,бичгийн давтлага өгснөөр 4 нь тэнцсэн.<br>-МУБИС-ийн оюутан Э.Ганхөлөг Уран бичлэгийн талаар сургалт зохион явуулж, бүтээлийн үзэсгэлэн гаргасан.<br>- ЕБС-ийн урлаг зааланд Чингис хааны эш хөргийг залж, Чингис хааны билэг сургаалаас үндэсний бичгээр бичиж байршуулсан.<br>- 2021 оны 4-р улиралд " Хүмүн бичиг" сонинг сурталчилах зорилгоор ЗДТГ,ЕБС,СӨББ, СДЭ, Соёлын төвд 2,2-ыг буюу нийт 10 сонин захиалсан. Цаашид албан байгууллагууд 100% | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;<br>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | захиалж ажиллахыг дарга,эрхлэгчдэд зөвлөг ажиллаж байна. | | |
| 21 | 21 | Жагсаалт батлах тухай 2021-12-01<br>Дугаар №359<br>4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай. | Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллаж байна. | 100 | |
| 22 | 22 | Үдийн хоолны норматив тогтоох тухай 2021-08-11<br>Дугаар №237<br>4.Энэ тогтоолын 1, 3 дахь заалтыг хэрэгжүүлэхэд 2021 онд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг 2021 онд батлагдсан төсвийн багцдаа зохицуулалт хийж, 2022 оноос улсын болон орон нутгийн төсвийн төсөлд зохих журмын дагуу тусган хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Ерөнхий боловсролын сургууль Үдийн хоолны хувьд дараах ажлыг хийж хэрэгжүүллээ.<br>- 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 9 бүлгийн нийт 197 суралцагч үдийн хоол хөтөлбөрт хамрагдаад байна. Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт тавих орон тооны бус хяналтын нэгж нь дотоод хяналтын нэгжтэй хамтран үдийн хоолны үйл ажиллагаатай танилцан эрүүл ахуй,халдвар хамгааллын дэглэм хэрхэн баримтлан ажиллаж буйд үнэлгээ дүгнэлт өгч ажиллалаа.<br>- Боловсролын салбарын нэгдсэн мэдээллийн систем дэх “Хоол бүртгэлийн систем” хэсэгт үдийн хоолны цэсний дэлгэрэнгүй тайлан , анги удирдсан багш нарын өдөр тутмын ирцийн бүртгэл, тогооч нарын хоолны мэдээллээ өдөр тутам бүрэн гүйцэд оруулж буйд хяналт тавьж хяналтын хуудсыг 7 хоног бүрээр татан авч хяналт тавьж ажиллалаа.<br>- Боловсролын мэдээллийн нэгдсэн системээс хоолны цэс болон бүлэг хамрагдалт, гүйцэтгэлийн тайлан /хоол орц, илчлэг шимт бодис, ирц/, хоолны хяналтын хуудас хэсгээс тогооч мэдээлэл оруулсан эсэх, хамрагдсан сурагчийн тоо, мэдээлэл оруулсан хугацаа, хоолны нэр, хоолны зураг, эцэг | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | эхийн дундаж үнэлгээ, эцэг эхийн сэтгэгдлийн тоо зэрэг үзүүлэлт тус бүрд 7 хоног тутамд хяналт тавьж ажиллалаа.<br>- Анги танхим болон бага сургуулийн гал тогооны эрүүл ахуй ,халдвар хамгааллын дэглэм баримтлах, хувийн эрүүл мэндийг хамгаалах талаар эрүүл мэнд,онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн заавар зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.<br>- Сургуулийн орчинд үдийн хоолноос хамааралтай хоол хүнсний хордлого гарахаас урьдчилан сэргийлэх замаар хяналтын зөвлөл болон дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, үдийн хоолонд өгөх бүтээгдэхүүнд шим тэжээллэг ,амин дэмээр баялаг хоол хүнсний бүтээгдэхүүнийг сонгон өгч байна.<br>- Анги удирдсан багш нар болон жижүүр багш, Shool police-ийн эргүүл жижүүр хийж байгаа эцэг эхчүүд өдөр тутмын хоолны амт чанарт хяналт тавьж тэмдэглэл хөтлөн ажиллаж хэвшсэн.<br>- Суралцагчид үдийн хоолны аяга халбага болон үдийн хоолны хэрэгс-лийнхээ болон хувийн ариун цэврийг өдөр тутам сахих, анги танхимдаа хүнсний бүтээгдэхүүн дамжуулж хэрэглэхгүй байх талаар анги удирдсан багш нар болон суралцагчдад мэдээлэл өгч ажиллалаа.<br>- Хүнсний бүтээгдэхүүн хадгалах складанд цэвэрлэгээ халдваргүйжүү-лэлтийг СДЭ- ийн заавар зөвлөмжийн дагуу сард 2 удаа хийж бараа бүтээгдэхүүнийг ангилан төрөлжүүлж хадгалалтын горимыг баримтлан ажиллаж байна.<br>- Сурагчдын бие бялдрын хөгжил болон улирлын томуу болон томуу тест өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчдын үдийн цайнд халуун аарц, сүү, үзэмний шүүс болон чацарганы шүүс гурилан бүтээгдэхүүн зэргээр байнга үйлчлэн долоо хоногийн 3 өдөр халуун хоол,цай, 2 өдөр цагаан хоол,аарц болон чацарганы шүүс өгч байна.<br>- Анги удирдсан багш ангийн сурагчдын бие бялдрын өсөлт хөгжлийг улирал тутам гаргаж биеийн жингийн индексийг өмнөх улиралтай нь харьцуулан өсөлт хөгжлийн судалгааг гарган ажиллаж байна.<br>- Хүнсний бүтээгдэхүүн хадгалах складыг тохижуулан бараа бүтээгдэхүүнийг ангилан төрөлжүүлж хадгалалтын горим болон халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | - Мөн үдийн хоол хөтөлбөрт бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх тендер зарласны дагуу Алтанжолоот хүлэг ХХК шалгаран гэрээ байгуулан 7-14 хоног тутамд хүнсний бүтээгдэхүү-нийг баталгааны бичиг, шинжилгээ, гарал үүслийн бичигтэй бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж байна.<br>Хүнсний бүтээгдэхүүн хадгалах складанд цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг СДЭ- ийн заавар зөвлөмжийн дагуу сард 2 удаа хийж бараа бүтээгдэхүүнийг ангилан төрөлжүүлж хадгалалтын горимыг баримтлан ажиллаж байна.<br>- Сурагчдын бие бялдрын хөгжил болон улирлын томуу болон томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчдын үдийн цайнд халуун аарц, сүү, үзэмний шүүс болон чацарганы шүүс гурилан бүтээгдэхүүн зэргээр байнга үйлчлэн долоо хоногийн 3 өдөр халуун хоол,цай, 2 өдөр цагаан хоол,аарц болон чацарганы шүүс өгч байна<br>-Эрүүл мэндийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 04 ний өдрийн 207дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан хоол үйлчилгээнд хориглох хоол, хүнсний түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн”-ий жагсаалтыг гаргаж 1-5 ангийн анги удирдсан багш ,нярав,тогооч нарт танилцуулж сурталчилсан.<br>-Сургуулийн нярав нь үдийн хоолны цэсийг тогооч нартай хамтран 7 хоног тутамд боловсролын мэдээллийн нэгдсэн ситемд хоолны хуваарийг оруулан цэсийн дагуу сурагчдад халуун хоол цай болон бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилж байна.<br>- Долоо хоног бүрийн Баасан гарагт хичээлийн байр, гал тогоо болон анги танхимд их цэвэрлэгээ хийж ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж хэвшсэн.<br>- Үдийн хоолны дээж бүртгэлийг тогтмол хөтлөх, устгал хийх үйл ажиллгааг тогтмол хийж, хөтөлж хэвшсэн. | | |
| 23 | 23 | / "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын дүрэм"/ Дүрэм шинэчлэн батлах тухай<br>2021.06.23 №173<br>3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэгийг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөөг багийн эмч нар цаг алдалгүй хүргэж хөгжлийн бэрхшээлтэй Хүүхэд, нярайн тусламж, үйлчилгээг стандартын дагуу хийж хүүхдийн гэрийн эргэлтийг 2023 оны эхний 6 сарын байдлаар давтан тоогоор 790 хүүхдэд гэрийн эргэлтээр үзэж ,нийт 0- 6 насны хүүхдийг хамруулсан. Мөн энэ оны 6 сарын байдлаар малчид отор нүүдэл хийж өөр аймаг сум руу шилжиж, үлдсэн хүүхүүдийг графикийн дагуу | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нарт, санхүүгийн зохих дэмжлэгийг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | багийн эмч нар гэрийн эргэлт хийж байна. Амин дэм Д сэргийлэлтийн тунг нийт хүүхдийн 90% хамруулж, А амин дэмийг 5 сард 95% хамрагдаад байна. | | |
| 24 | 24 | "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл" батлах тухай 2021.03.10 №58<br>3.Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай. | 2023 оны хагас жилийн байдлаар Залуучуудын оролцоо төсөл зарлагдаагүй байна. | - | |
| 25 | 25 | Дүрэм шинэчлэн батлах тухай 2021.03.17 №67<br>2."Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм"-ийн хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт, хэрэгжүүлж ажыг Нийгмийн даатгалын ерөнхий газар Д.Зоригт, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.<br>4.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэж, даатгуулагч иргэнийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн сайл С.Энхболд, аймаг, дүүргийн Зас аг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдалтын тахир дутуугийн тэтгэвэр авдаг иргэнийн мэдээллийг эмнэлэг нэг бүрчлэн тулган хянаж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр иргэдэд хандсан сургалт, сурталчилгааг 7 хоног болгон хийж гэрийн эргэлтийг багийн эмч нар судалгааг гаргаж сард хоёр удаа үзлэг шинжилгээг хийж их эмч нар сардаа нэг удаа хянан гарын авлага, зөвлөмжөөр хангаж, багийн эмч, багийн дарга нартай хамтран ажилж байна. Эрүүл мэндийн төв нь хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийг хэвтэн эмчлүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангах, таатай орчин нөхцлийг бүрдүүлэх зэрэг ажлууд бүрэн хийгдсэн байна. 2023 оны эхний 6 сарын байдлаар нийт 18 иргэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлээд байна. | 100 | |
| 26 | 26 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2021.02.24 №47<br>3.Эрсдэлгүй ногоон бүсэд танхимын хичээл, сургалтын үйл ажиллагаа үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан төрийн өмчийн цэцэрлг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг зохих журам, зааврын дагуу ариутгаж халдавргүйжүүлэхэд нэн шаардлагатай ариутгалын бодим, багаж, хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | СӨББ Ариутгал халдаргуужилтыг хавар намар мэргэжлийн байгууллагаар хийлгэж хэвшсэн. БШУЯамнаас халдаргүүлжүүлэлтийн Каварцын гэрлыг өгч ажлуулах горимын талаар сургалт чиглэл өгсөн. ЕБС-ийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хамгаалах талд анхаарч 7.5 сая төгрөгөөр хайс хийж нийт 200 гаруй мод бут тарьсан. Шаардлагатай үед анги танхимыг ариутган халдваргүйжүүлэх бодисыг худалдан авч нөөцлөн ажиллаж байна | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 27 | 27 | Төлөвлөгөө батлах тухай<br>2021-01-20 Дугаар №18<br>2. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор батал сугай.<br>3. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутгийн жил бүрийн холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | Ерөнхий боловсролын сургуулийн хоолүйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй, тогтвортой, хүртээмжтэй тогтолцоог бий болгох, суралцагчийг шимтэжээллэг хоол хүнсээр хангаж эрүүл мэндийг нь дэмжих зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.<br>-Үдийн хоол хөтөлбөр болон дотуур байрны сурагчдын хоол үйлдвэрлэлд бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх тендер зарласны дагуу сумын "Алтан жолоот хүлэг" ХХК шалгаран гэрээ байгуулан 14 хоног тутамд хүнсний бүтээгдэхүүний баталгааны бичиг, шинжилгээ,гарал үүслийн бичигтэй бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж байна.<br>- Хүнсний бүтээгдэхүүн хадгалах складыг тохижуулан бараа бүтээгдэхүүнийг ангилан төрөлжүүлж хадгалалтын горим болон халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байна.<br>- Сургуулийн орчинд болон хоол үйлдвэрлэлийн газраас хамааралтай хоол хүнсний хордлого гарахаас урьдчилан сэргийлэх замаар хяналтын зөвлөл болон дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, үдийн хоол болон дотуур байрын сурагчдын хоолонд өгөх бүтээгдэхүүнд шим тэжээллэг ,амин дэмээр баялаг хоол хүнсний бүтээгдэхүүнийг сонгон өгч байна.<br>- Ерөнхий боловсролын сургуульд хүүхдийн насны онцлогт тохирсон эрүүл, аюулгүй хоол хүнсний үйлчилгээг үзүүлэх зорилгоор Өвөрхангай аймгийн БШУ-ны газраас зохион байгуулсан ЕБС-ийн тогооч нарын ур чадварын уралдаан болон сургалтанд 2 тогооч хамрагдсан.<br>-Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээг шинжлэх ухааны үндэстэйгээр хөгжүүлэх, суралцагчдад шим тэжээллэг хоолоор үйлчлэх , тэдэнд шим тэжээлийн мэдлэг олгох үүднээс гаргасан "Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны жор технологи" гарын авлагыг тогооч нараар уншиж судлуулан суралцагчдын өсөлт хөгжилтийг хангахуйц тэнцвэртэй, шим тэжээллэг хоол хүнс бүхий 66 иж бүрдэл хоолноос өөрийн сургуулийн нөөц боломжиндоо тулгуурлан дотуур байр болон үдийн хоолны үйлдвэрлэлдээ ашиглаж байна. | 100 | |
| 28 | 28 | Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2021.02.17 №43 | Хуваарилагдсан төсвийг зүйл заалтын дагуу зарцуулахын сацуу төсвийг хэмнэх талаар авч буй арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1. Монгол улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай. | | | |
| 29 | 29 | Түр хороо байгуулах тухай 2021.02.10 №29<br>4. Түр хороо, Ажлын шуурхай хэсгийг үнэн зөв, бодит мэдээллээр тухай бүр хангаж, мэдээ, мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байх, нийтэд буруу ташаа, үндэслэлгүй мэдээ мэдээлэл тараахгүй байх, тараасан бол холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Сумын Засаг Даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/ 24 захирамжаар гамшиг ослын үед ажиллах Сургалт сурталчилгаа болон иргэдэд мэдээлэл хүргэх албан тушаалтаныг томилгоожуулж бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэдэд мэдээ мэдээллийг Өвөрхангай Есөнзүйл Здтгазар, Есөнзүйл сум ЗДТГ, Есөнзүйл Онцгой Комисс, гэсэн цахим хуудсуудаар шуурхай хүргэн ажиллаж байна. Мөн мессеж модем ашиглан өрх бүрт мэдээллийг тухай цаг бүрт нь хүргэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. | 70 | |
| 30 | 30 | Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай 2020.05.06 №163<br>3. Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай. | Сумын төсөвт байгууллагууд төрийн албаны цалингийн нэгдсэн системд нэвтрэх эрхийг аван хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулсан мэдээллийг төрийн албаны цалингийн нэгдсэн системд татан төрийн албан хаагчдын цалин хөлсийг тооцоолж цахимаар цалинг олгож эхлээд байна. | 100 | |
| 31 | 31 | Журам батлах тухай<br>2020.03.25 №113<br>1. "Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай. | Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын хүрээнд 1 хоршоо, 3 Аж ахуй нэгж, 18-н иргэний төсөл "Төсөл сонгон шалгаруулах хороогоор" хэлэлцэгдсэнээс 1 хоршоо, 3 Аж ахуй нэгж, 8 | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | иргэний төсөл тэнцэж үнэлгээний хороонд хүргүүлж ажиллаа. Хоршоо хөгжүүлэх сангаас 180 сая төгрөгийн санхүүжилтээр сумын тэргүүлэх чиглэлийн хүрээнд<br>✓ Эсгий үйлдвэрлэл: 1 Хоршоо<br>✓ Авто машин засвар үйлчилгээ: 1 ААН Хоршоо-1<br>✓ Бууз, банш, хэрчсэн гурилын цех :1 ААН ААН-3<br>✓ Зочид буудал, цайны газар: 1 ААН Иргэн-10<br>✓ Сүү, Цагаан идээ боловсруулах : 4 иргэн<br>✓ Мах, дайвар бүтээгдэхүүн: 1 иргэн<br>✓ Гутал, монгол гутал үйлдвэрлэл: 2 иргэн<br>✓ Хэрчсэн гурил үйлдвэрлэл: 1 иргэн<br>✓ Оёдол: 1 иргэн<br>✓ Нэхмэл шүр: 1 иргэн<br>Төслийг сонгон шалгаруулж 1 хоршоо, 3 ААН, 8 иргэний төслийг дэмжин сум орон нутагтаа ажлын байр бий болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлэн амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлж ажиллалаа. Уг зээл авсан аж ахуйн нэгж, хоршоо, иргэдийн үйл ажиллагаанд 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хяналт шалгат хийхэд үйл ажиллагаа жигдсэн явагдаж байна. | | |
| 32 | 32 | Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай<br>2020.03.25 №106<br>1. "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн дараа аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 106 дугаар тогтоолын дагуу сумын төлөвлөгөө боловсруулан биелэлтийг хангаж ажиллаж байна. Архивын ORG-AMS программыг архивын ажилтаны комьютерт суулган захирамжлалын баримт бичиг, явуулсан бичиг өргөдөл гомдолыг тус бүрээр шивэж оруулан архив, бичиг хэргийн эрхлэгчийн гүйтэтгэлийн төлөвлөгөөнд архивын баримтыг цахим тоо хэлбэрт оруулах заалтыг нийтийн ажил үйлчилгээнд зааж биелэлтийг хангаж ажилласан. Сумын Засаг дарга 2023 оны 06 дугаар сарын 20-ны байдлаар үйл ажиллагааны чиглэлээр 77, боловсон хүчний чиглэлээр нийт 7 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын үйл ажиллаганы чиглэлээр 3, боловсон хүчний чиглэлээр 16 | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тушаалыг тус тус шивж оруулаад байна. EPSON маркийн өнгөт принтер, DELL брендийн суурийн компьютер, EPSOM маркийн түргэн скайнераар хангагдсан. Сумын веб хуудсыг хийлгэх ажилд 750000 төгрөгийг зарцуулж уг хуудсаа байгууллагын ил тод байдал болон архив, албан хэрэг хөтлөлтөнд ашиглаж байна. Байгууллагын бичиг хэргийн ажилтаны албан тушаалын тодорхойлолтонд албан хэрэг хөтлөлтийн талаар болон архивын бичиг баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх талаар хүлээх эрх үүргийг тусгаж хөдөлмөрийн гэрээ байгуулан биелэлтийг ханган ажиллаж байна. | | |
| | 33 | 2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч үүрэг болгосугай. | Байгууллага бүр архивын өрөөгөө тохижуулан техник хэрэгсэл ном гарын авлагаар ханган үйл ажиллагаа явуулж байна. Архив бичиг хэргийн эрхлэгч нар байгууллагын архивт ажилтнуудаас баримт бичгийг ХХНЖагсаалт болон хуваарийн дагуу баримтыг хүлээн авч архивын нөхөн бүрдүүлэлтийг жил бүр хийж ажиллаж байна. Суманд тэмдэглэж буй түүхэн ой онцлог үйл явдлын холбогдолтой баримт бичиг болон дүрс бичлэгийг CD дээр буулган файл болон цаасан хэлбэрээр архивт хадгалж байна. | 70 | |
| 33 | 34 | Үндэсний хөтөлбөр батлах тухай<br>2020.03.18 №96<br>1. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн дэмжлэгээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ыг хэрэгжүүлэн дараах ажлыг хийж гүйцэтгэлээ<br>- Монгол бичгийн танхимд хичээл сургалтын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж байна. Тус танхимын сургалтын хэрэглэгдэхүүнийг баяжуулан сурагчдын суралцах таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байна. "Зүйр цэцэн үгс" А4 үзүүлэнг 40 ш, "Монголбичгийн үсгийн карт" 140ш үзүүлэнг үндэсний бичгээр хэвлэн сургалтад ашиглаж байна. Мөн ханын үзүүлэнг сурагчдад хүртээмжтэй байдлаар хөдөлгөөнт маягаар байршуулан ашиглаж байна.<br>-Монгол бичгийн кабинетын орчинг Үндэсний бичгээр тохижуулсан \ гуравласан сүлжээ сургаал \<br>Ахлах ангийн сурагчдаар " Цахим орчинд зөв хэрэглээнд " уриан дор Chime аппейклешныг ашиглан бичих чадварт сурган<br>- Ахлах ангийн сурагчдаар уран бичлэгийн бүтээл, дунд ангийн сурагчдаар "Үлгэрийн ертөнцөөр аялцгаая"-зурагт үлгэрийн ном тус тус хийлгэсэн. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | - ЕБС-ийн урлаг зааланд Чингис хааны эш хөргийг залж, Чингис хааны билэг сургаалаас үндэсний бичгээр бичиж байршуулсан.<br>- Нийт 110 ТАХ-ыг Монголбичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтад хамруулан,бие даан сурах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>- 2021 оны 4-р улиралд " Хүмүн бичиг" сонинг сурталчилах зорилгоор ЗДТГ,ЕБС,СӨББ, СДЭ, Соёлын төвд 2,2-ыг буюу нийт 10 сонин захиалсан.Цаашид албан байгууллагууд 100% захиалж ажиллахыг дарга,эрхлэгчдэд зөвлөсөн.<br>-Үндэсний бичгийн хичээлийг үр дүнтэй зохион байгуулах \6-12-р анги\: 6-12-р ангийн үндэсний бичгийн хичээлийг үр дүнтэй зааж сурагчдыг зөв бичих, шударга унших чадварт сургаж байна.<br>-Бичиг соёлын хишиг өдрийг тэмдэглэх: Бичиг соёлын хишиг өдрийг тэмдэглэн "Үндэсний бичиг соёл-2023"- өдрийг сурталчилан , олон нийт, сурагчдын идэвхийг өрнүүлж төрөл бүрийн уралдаан зохион байгуулан ажилласан<br>Отгонбаатар багшийн "Цахимд эвхмэлээр бичих аргазүй"- сургалтад хамрагдлаа.<br>-12-р ангийн 7 сурагчийг ЭЕШ-д бэлтгэн, давтлага өгч, МХБ-ийн хичээлийн шалгалтад 12-р ангийн 18 сурагчийг амжилттай оролцууллаа.<br>-Төрийн албан хаагчдын монголхэл, бичгийн мэдлэг чадварын түвшинг тогтоож үнэлэх, чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах: Улс орон даяар зохион байгуулсан Төрийн албан хаагчдын "Монголбичгийн түвшин тогтоох" судалгаанд бүрэн хамруулан ажилласан.<br>-Төрийн байгууллагад албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулах бэлтгэл хангах: 2025 онд албан бичгийг хос бичгээр хөтлөх болсонтой холбоотойгоор бэлтгэл ажлыг хангахын тулд төрийн албан хаагчдыг анхан, дунд шатны сургалтад хамруулан ажиллаж байна. | | |
| 34 | 35 | Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай<br>2020.02.28 №78<br>8. Энэ онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан | Тендерийн ерөнхий төлөвлөгөөг Засаг даргаар батлуулж tender.gov.mn-д оруулж яамаар батлуулан ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангийн баримт болон ажилд хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээллийг шилэн данс болон мэдээллийн самбар, сумын вэб сайтанд байршуулан ил тод байдлыг хангаж ажиллаж байна. 2023 оны тендерийн бүх үйл | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шуурхай зохион байгуулж, мэдээллийг ил тод нийтэлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | ажиллагааг цахимаар зарлан ил тод байдлыг хангаж ажиллалаа. | | |
| 35 | 36 | Үндэсний хөтөлбөр батлах тухай<br>2020.01.29 №34<br>1. "Монгол малчин" үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай<br>3, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвт багтааж хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Монгол малчин үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сумын хэмжээнд 750 хонь 350 ямааг ээмэгжүүлэн малын бүртгэлийн программд оруулан ажиллалаа. Мөн 200 бод малыг ээмэгжүүлэх ажлыг 2023 оны 08 дугаар сарын 10-20 дотор хийж гүйцэтгэхээр бэлтгэл байдлыг ханган ажиллаж байна | 70 | |
| 36 | 37 | Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай<br>2019.05.01 №185<br>4. 2019 оны бэлчээр хамгааллын арга хэмжээг нийтийг хамарсан ажил болгон зохион байгуулах, цаашид жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг "Бэлчээр хамгаалах өдөр" болгон зарлаж, мэрэгч амьтан, шавжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах бүх нийтийн арга хэмжээг сум, багийн түвшинд зохион байгуулж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | 2023 оны 04 сарын 14 өдрөөс 2020 оны 04 сарын 18 өдөр хүртэл хугацаанд Өвөрхангай аймаг Есөнзүйл сумын нутагт микробиологийн аргаар мэрэгчидтэй тэмцэх ажлыг хэрэгжүүлж дуусгаад, орон нутгийг төлөөлж ажлын хэсгийн ахлагч С.Бат-Эрдэнэ болон ажлын хэсгийн гишүүд Г.Мөнх-Эрдэнэ, Ж.Эрдэнэбилэг Ц.Мягмарсүрэн, П.Амазаяа, Г.Очир, Э.Батсүх, Г.Төмөрбаатар, Г.Амарцргт, Д.Бат-Эрдэнэ хяналтын ажилтан байгаль орчны мэргэлжилтэнг түр орлон гүйцэтгэгч М.Буяннэмэх нар оролцож микробиологийн аргаар мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээнд хамрагдсан талбайг сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөв. Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын 2, 3, 4 дүгээр багийн бэлчээрийн хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээнд хамрагдсан 2 дугаар багт Мөнхбула, Даншигдэнж 3 дугаар багт Мэлзэн, Олон түрүүний го 4 дүгээр багт Зүүн гол хэсгийн 2,3 га талбайд оготно устгалын ажлыг хийж гүйцэтгээд байна. Нийт нутгийн хэмжээ 221,8 мянган га, Бэлчээрийн газар 214,5 мянганга, оготно тархсан талбай 176,9 мянган, тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлсэн нийт талбайн хэмжээ 23000 га, тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлсэн талбайг нийт нутагтай харьцуулсан хувь 1,13 % оготно тархсан талбайн 1,4 %. цаашид тэмцэх арга хэмжээ авах шаардлагатай талбайн хэмжээ 174370 га, ажлын техник үр дүн 89.2% сумын Засаг даргын ажлын дүн хэлэлцсэн хурлын тэмдэглэл дүгнэлтүүдийг үндэслэн мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлсэн бэлчээрийн талбайг орон нутагт хүлээлгэн өгсөн | 100 | |
| 37 | 38 | Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай<br>2019.03.21 №111 | 2022 онд Сум дундын эмнэлэг 1, ЕБС- 2, Засаг даргын Тамгын газар 1, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1 хөгжлийн | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай. | бэрхшээлтэй иргэнг хууль журманд заасны дагуу ажиллуулж байна. | | |
| 38 | 39 | Журам батлах тухай<br>2019.01.09 №9<br>Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам.<br>1.1 Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан үндэслэлээр, мөн хуулийн 43 дугаар зүйлд заасан журмын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид цалин, урамшуулал олгоход энэ журмыг баримтална. | Журмын дагуу түр орлон гүйцэтгэж байгаа албан 5 төрийн захиргааны албан хаагчдад урамшууллыг олгож ажиллаж байна. Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн, Хүнс, Ждү хариуцсан мэргэжилтэн, Санхүү албаны дарга, Төсөв төрийн сангийн мэргэжилтэний орон тоог түр орлон хавсран гүйцэтгэж байна. | 100 | |
| 39 | 40 | Журам батлах тухай<br>2019.01.09 №7<br>2.1 Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам. 1.1. Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход энэ журмыг мөрдөнө. | Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсч тэтгэвэрээ тогтоолгоод байгаа бөгөөд орон тооны хосдлоос үүдэн холбогдох дээд байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Есөнзүйл сумын эрүүл мэндийн төвийн Лаборант П.Энхтуяа Эзлжийн сувилагч Д.Сарантуяа нар тэтгэвэрт тогтоолгох эрх нь үүсэж тэтгэвэрээ тогтоолгосон байна. Нэн шаардлагатай байгаатай холбогдуулан тэтгэвэрт гарсан 2 хүнээ хөдөлмөрийн гэрээгээр 2022 оны 07 сараас байгуулан ажиллуулж байна. | 100 | |
| 40 | 41 | Журам батлах тухай<br>2019.01.09 №6<br>Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам<br>2.1 Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно | Засаг даргын Тамгын газрын хувьд 2023 оны эхний хагас жилийн хувьд Төрийн албан хаагчдыг нийт өссөн дүнгээр 18 албан хаагчийг дотоодын сургалтад хамруулж 4310,000 төгрөгийн томилолтын зардлыг олгож томилолтын зардлын өргүй ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн хувьд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанууд дээд шатны байгууллагт сургалтанд хамрагдахад томилолт болон шаардлагтай үед шатахуун дээр дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Төгсөлтийн дараах богино хугацааны 03-06 сарын хугацаанд үнсэн цалинг олгож төрийн сангаар сургалтын төлбөрийг төлж суралцуулдаг. Соёлы төвийн хувьд 2023 оны хагас жилийн | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байдлаар 3 албан хаагчдад 186000 төгрөгний томилолтын мөнгийг олгосон байна. | | |
| 41 | 42 | Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2019.01.03 №57<br>1. Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.<br>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | 2023 оны хагас жилийн байдлаар Хурдан морь унаач хүүхэд болон уяачдын судалгааг гаргаж, өвөл хаврын хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байх чиглэлээр Уяачдын холбоо болон багийн Засаг дарга нарт мэдээлэл өгч уралдаан зохион байгуулахыг хориглосон Засаг даргын албан тоотыг Уяачдын холбоонд хүргүүлэн мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулан хяналт тавин ажиллалаа. Мөн цагдаагийн хэсэгтэй хамтран албан мэдэгдлийн хүрээнд тус хугацаанд уралдаан болох гэсэн мэдээллийг дагуу хяналт шалгалт хийн үнэн худлыг илрүүлэн хяналт тавин ажиллалаа. | 100 | |
| 42 | 43 | Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай<br>2018.08.22 №258<br>1.Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай<br>Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, сургал тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх | Байгууллага тус бүр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн актууд, дүрэм журам болон бусад тогтоол шийдвэрүүдийн нэгдсэн цахим сантай болж, шинээр гарсан тушаал шийдвэрүүдийг цаг хугацаанд нь албан хаагчиддаа танилцуулан мөрдөн ажиллаж байгаа бөгөөд мэдээллийн самбарт тогтмол байршуулж байна. Төрийн албан хаагчдийн сахилга хариуцлага дэг журмыг чангатгах үүднээс албан хаагчдад байгууллагын дотоод журмыг дахин танилцуулж гарын үсгийн баталгааг авч мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сахилга хариуцлага, ёс зүйн зөрчилгүй ажиллах талаар ажлыг тусган хэрэгжилтийг нь тооцон ажиллаж байна. Мөн төрийн албан хаагч бүрээр Төрийн албаны манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, төрийн хууль ёсыг чанд сахин аймаг орон нутгийнхаа хөгжлийн төлөө эрдэм чадлаа зориулж, өөрийн болон байгууллага, хамт олныхоо нэр төр, соёлч байдлыг эрхэмлэн иргэдийг ялгаварлахгүйгээр ижил тэгш, зөв шударга харьцаж, ажлын цагийг цалгардуулж хийдүүлэхгүй, бүтээмжээ нэмэгдүүлж, аливаа хууль бус дарамт шахалтад автахгүй, үйлдэхгүй, албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байхаа илэрхийлж баталгаа гаргуулан аваад байна. Мөн 2023 оны эхний хагас жилийн байдлаар ёс зүй болон сахилгын зөрчил илэрсэн байдал илрээгүй байна. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 44 | 2. Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 09 дүгээр сарын 1 -ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх | Есөнзүйл суманд 2023 оны 02 дугаар улирлын байдлаар нийт 161 өргөдөл хүлээж авсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 305 өргөдөл хүлээн авч бүх өргөдлийг 100% шийдвэрлэж ажилласан байна. Ирүүлсэн нийт өргөдлүүд 100% бичгээр ирсэн бөгөөд бүртгэл хяналтын карт үүсгэн шийдвэрлэх ёстой хугацаанд нь шийдвэрлэж ажилласан байна. Ирсэн өргөдлөөс нийгмийн халамжтай өргөдөл хамгийн өндөр хувийг эзэлж байна. Байгууллагын үйл ажиллагаатай болон материал мөнгөн тусламж хүссэн өргөдөл ирээгүй байна. Байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг бэлтгэсэн маягтын дагуу цахим болон цаасаар баталгаажуулан авч ажиллаж байна. Албан байгууллага болон өргөдөл гомдол хүлээн авч буй албан хаагчдад "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн дагуу өргөдөл хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөөг өгөн ажиллаж байна. | 100 | |
| | 45 | 3.Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах | Төрийн албан хаагч бүрийн ажлын байрны дүн шинжилгээ хийж төсвийн шууд захирагч нарын тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Байгууллага тус бүр ажиллагсдын албан тушаалын тодорхойлолтыг ажлын давхардал, хийдэлгүйгээр загварчлан боловсруулсан бөгөөд ажиллагсад албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажиллаж байна. | 70 | |
| | 46 | 4.Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн албыг бэхжүүлэх | Тус сумын Засаг даргын Тамгын газарт 2023 оны хагас жилийн байдлаар Хүнс, ЖДҮ хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн, Мал аж ахуйн мэргэжилтэн, Төсөв төрийн сангийн мэргэжилтэн нарын сул ажлын байруудын захиалгыг Өвөрхангай аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн төрийн албаны тусгай шалтгалтыг зарлуулан ажиллаж байна. 2023 оны хагас жилийн байдлаар Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн төрийн албаны тусгай шалгалтанд тэнцэн тухайн албан тушаалд томилогдон ажиллаж байна. | 70 | |
| | 47 | 6.Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш | Жирэмсэний болон амаржсаны амралттай 2 албан хаагч байгаа бөгөөд хууль журмын дагуу нийгмийн даатгалын | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх. | шимтгэлийг төлж байна. Одоогоор богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж буй жинхэнэ албан хаагч байхгүй байна. | | |
| | 48 | 7.Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажпын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хэрэглэх, хадгалах, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох | Албан байгууллагуудын дотоод журманд ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажпын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хэрэглэх, хадгалах, ашиглахыг хориглож зөрчсөн тохиолдолд ямар арга хэмжээ тооцохыг тусган оруулж тухай бүр хяналт тавин ажиллаж байна. | 70 | |
| | 49 | 10.Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах | Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага тооцож ажиллах талаар байгууллагын дотоод журманд тодорхой заалтуудыг оруулан мөрдөн биелэлтийг нь хангаи ажиллаж байна. Сумын хэмжээнд зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна. | 100 | |
| 43 | 50 | Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай 2018.06.20 №189<br>2. Хог хаягдлын эдийн засгийн зохицуулалтыг сайжруулах, үүсгэгч нь хариуцаж, бохирдуулагч нь төлөх эко төлбөрийн эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад даалгасугай. | Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуйн нэгжүүд болон хүнсний дэлгүүрүүд, ард иргэдийн ундны ус хангагч худгууд, Засаг даргын Тамгын газрын зарын самбар, сумын цахим хаягаар, цагдаагийн хэсэг, гэх мэт газруудаар Өвөрхангай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас гаргасан "Уриалга", Засгын газрын 189 дүгээр тогтоол зэргээр боршур хийж иргэдэд сурталчлах мөн уриалгыг байршуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>Мөн зорилтод бүлгийн иргэд болон аж ахуйн нэгж албан байгууллагуудын албан хаагчдад Засгын газрын 189 дүгээр тогтоол, Уриалга, хог хаягдлын тухай хууль, байгаль орчны тухай хууль, олон удаа хэрэглэгдэх цаасан болон даавуун уутыг хэрэглэж занших, түүнийг өөрсдийн нөөц боломжоор хийж хүнсний дэлгүүрүүдээр худалдан борлуулах талаар хамтран сургалт сурталчилгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | 100 | |
| 44 | 51 | Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай. | Төрийн албан хаагчдад ажлын 8 цагийн хүрээнд олон нийтийн сүлжээ онлайн тоглоом болон видео сан бүхий | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2018.05.23 №138<br>2. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй. | сайтад нэвтрэхгүй байхыг зөвлөж тогтоолын биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газарт албаны мэйл хаяг нээн албан бичгийг дээд байгууллагатай солилцон ажиллаж байна. | | |
| 45 | 52 | Гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай.<br>2018.04.06 №68<br>1.5. Гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын шаардлагыг хангуулахтай холбоотой үйл ажиллагаанд өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, уялдаа, зохион байгуулалтаар хангахыг Монгол Улсын Шадар сайд, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай. | Өвөрхангай аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн "Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлын хэсэг томилох тухай" А/274 дүгээр захирамжийн дагуу сумын хэмжээнд гамшгаас хамгаалах команд штабын сургуулилт зохион байгуулагдлаа.<br>-Сумын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 15:00 цагт дуут дохиогоор цугларч бэлтгэл бэлэн байдлыг шалгаж ажилласан. Мөн өдрийн 17:00 цагт мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хээрийн үүргэвчийг шалгасан. -Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 15 цаг 25 минутанд Мөнхбулаг 3 дохиогоор дуудаж сэргээн босголтын ажлыг хийж эхэлсэн. Сэргээн босголтын ажлаар сумын төвийн айл өрхүүдийн хашааг тэгшлэн гарниз мод хадаж хээ тавих ажлыг зохион байгуулж байна. Оройн 21 цаг 30 минутын байдлаар 20 айлын хашаанд хээ тавьж 88 гарниз модыг хадсан байна.<br>-2023 оны 05 дугаар 17-ны өдрийн шөнийн 02:10 цагт Мөнхбулаг-3 дохиогоор сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн сумын яаралтай цугларах талбайд цуглан хээрийн сургуулалт хийлээ. Хээрийн сургуулилтад нийт онцгой комиссын 57 гишүүний бүрэлдэхүүнтэй хамрагдаж, хээрийн нөхцөлд хээрийн үүргэвчинд байгаа хоолны материалаар 4 багт хуваагдан хоол хийж, анхны тусламж үзүүлэх сургалтыг зохион байгууллаа. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | -2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 14:30 минутанд сумын төвийн Мөнхбулаг 2 дугаар багт байрлах хуучин Соёлын төвийн барилга дээр дуурайлан үзүүлэх дадлага сургууль боллоо. Дуурайлан үзүүлэх дадлага сургууль нь "7.6 магнитудын газар хөдлөлт болж, газар хөдөлсний улмаас тархалт ихтэй гал түймэр гарч байна, 3 хүн нурангинд дарагдаж барилгаас гарч чадахгүй байна" гэсэн бодит байдал дээр сумын Онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн хамтран зохион байгууллаа. | | |
| 46 | 53 | Үндэсний хөтөлбөр батлах тухай. 2018.02.14 №50 Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | 2023 оны эхний хагас жилийн байдлаар 60 актаар сангаа баяжуулж одоогоор хууль тогтоомжийн бүртгэлийн лавламжийн санд 7293 эрх зүйн акт байна. Мөн 60 зүйл заалтаар өөрчлөлт хөдөлгөөнийг хийсэн байна. Шинээр гарсан хууль тогтоомжууд, тогтоол шийдвэрүүд болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийг бүртгэл хяналтанд авч хувийн хэрэгжүүлж холбогдох албан тушаалтанд танилцуулж ажиллаж байна. Холбогдох дээд байгууллага болон бусад байгууллагаас ирсэн хугацаатай болон хариутай бичгүүдийг тухайн цаг хугацаанд нь хариуг нь хүргүүлж ажиллаж байна. Төсвийн байгууллагын бичиг хэрэг, тушаал шийдвэрүүдэд хяналт тавин ажиллаж байна. Сумын Засаг дарга 2023 оны 06 дугаар сарын 20-ны байдлаар үйл ажиллагааны чиглэлээр 77, боловсон хүчний чиглэлээр нийт 7 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын үйл ажиллаганы чиглэлээр 3, боловсон хүчний чиглэлээр 16 тушаал гарч тухайн цаг бүрт нь боловсруулалт хийн хэрэгжүүлэн ажиллаж байна. Хууль зүйн чиглэлээр 2023 оны хууль эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хууль тогтоомжийг иргэд, төрийн албан хаагчдын дунд хийсэн сургалт сурталчилгааны ажлыг сумын ЗДТГ-ийн "Esunzuil_Zdtgazar", Есөнзүйл сум ЗДТГ, сумын онцгой Комисс, Есөнзүйл сум ГХУСЗ зэрэг цахим хуудсанд тогтмол мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. Цахим хуудсанд 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 9 агуулгын хүрээнд мэдээ мэдээлэл, гарын авлагыг бэлтгэн иргэдэд хүргэж ажилласан бол монгол улсын хуулиудтай холбогдох заалт, арга хэмжээ, зохион байгуулж буй үйл ажиллагаа зэргийг иргэдэд цахим | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хуудсаар тогтмол хуваалцаж ажиллалаа. Энэ улиралд нийтлэг хэм хэмжээ тогтоосон захирамж болон захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж гараагүй. | | |
| 47 | 54 | Аргачлал шинэчлэн батлах тухай<br>2018.1.24 №20<br>Аргачлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг дараа оны 2 дугаар сард багтаан "Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем"-д оруулан баталгаажуулж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Орон нутгийн хөгжлийн индекс тогтоох 20 дугаар тогтоолын дагуу жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны өдөр багтаан http://ldi.nda.gov.mn/ цахим хаяг индексийн мэдээг оруулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэст индексийн мэдээг хүргүүлж байна. | 70 | |
| 48 | 55 | Дүрэм батлах тухай<br>2018.01.03 №4<br>1. Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрмийг 1 дүгээр хавсралт, орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлалсугай. | Засаг даргын 2023 оны 03 сарын 17-ны өдрийн А/22 дугаартай захирамжаар Залуучуудын хөгжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулж жилийн үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Залуучууд хөгжлийн зөвлөлийг 19 гишүүнтэй, дөрвөн багийн дэргэдэх залуучууд хөгжлийн зөвлөлийг 11 гишүүнтэй байгуулан арга зүйгээр ханган ажиллаад байна. | 70 | |
| 49 | 56 | Журам батлах тухай<br>2017.12.13 №340<br>2. Жирэмсэн эхийн тэтгэмжийн хэмжээг сард 40.000 (дөчин мянган) төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг сард 50.000 (тавин мянган) төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 1.000.000 (нэг сая) төгрөг, 3 болон түүнээс дээш ихэр хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 3.000.000 (гурван сая) төгрөг байхаар тус тус тогтоосугай. | Жирэмсэн эхийн тэтгэмжийн 40,000 төгрөгийг сар бүр 14 иргэнд, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийг сар бүр 104 иргэнд тус тус олгож ажиллаж байна. 2023 оны хагас жилийн байдлаар ихэр хүүхэд төрөөгүй байна. | 100 | |
| 50 | 57 | Хөтөлбөр батлах тухай<br>2017.03.20 №98<br>3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо"-нд, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Сумын хэмжээнд их цэвэрлэгээг 2023 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд нийтийн эзэмшлийн талба болон айл өрүүдийг нийтэд уриалах нийтийн цэвэрлэгээг зохион байгууллаа. Есөнзүйл сумын төвийн 250 гаруй айл өрхийн 90 гаруй хувь нь байгальд ээлтэй уламжлалт эко түлш болох аргалыг түлшний хэрэгцээнд тогтмол хэрэглэж байна. Мөн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж их цэвэрлэгээнээр сумын төвийн хогийн цэгийг дээш шууж цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хогийн цэгийн хогийг түрж янзлах болон хог асгах | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зориулалтын нүхийг ухан цэвэрлэх ажлыг Арвайхээр сумын иргэнтэй гэрээ байгуулан 8 өдрийн турш хийж гүйцэтгүүлээд байна. | | |
| 51 | 58 | "Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2017.02.01 №46 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулан хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд тус тус үүрэг болгосугай. | Нийгэмд түгээмэл буй архидан согтуурар гэр бүлийн хүчирхийллийн бууруулах чиглэлээр тус сумын ГХУСАЗСЗ даргат болон багийн засаг даргатай хамтран хариуцсан сумандаа өдөр,орой эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллалаа. Үүрэг гүйцэтгэх хугацаандаа Зориулалтын бус газар архидан согтуурсан, олон нийтийн гудамж тайлбайд бие зассан , хог хаясан болон бусдын амгалан тайван байдлыг алдагуулсан гэх нийт хэв журамын зөрчил илрүүлэн хариуцлага хүлээлгэн ажилласан. Цаашидаа гэмт хэрийг таслан зогсоох чиглэлээр хариуцсан сумандаа эргүүлийн үүргийг эрчимжүүлэн ажиллах болно. Мөн 21 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байх тал дээр хяналт тавин ажилласан. Сумын хэмжээнд архинд донтох өвчтэй болсон этгээд өөрийн санаачилгаар эмнэлгийн байгууллагад хандаж сайн дурын үндсэн дээр эмчлүүлэх хүсэлт гаргасан болон архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлүүлсэн хүн байхгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг хоёр иргэнтэй архины хор хөнөөл болон ёс суртахууны талаар сургалт зохион байгуулж дахиж ийм зөрчил гаргахгүй байх талаар баталгаа авч ажилласан. Гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл хүлээн авах 102, гэр бүл хүчирхийллийн тусламжийн 107, хүүхдийн тусламжийн 108 дугаарыг иргэд, олон нийтэд сурталчилж, хүнсний дэлгүүрүүдийн мэдээллийн самбарт байршуулж ажилласан. Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газрын адргын баталсан магестрал замд хяналт шалгалтыг цагийн хуваарийн дагуу тогтмол хийж, Хурд, Гэрэл сумын гарцанд дээр буюу Улсын А/301 магстрал зам 7 хонгийн 3 хугацаанд цагийн менежментийн үүрэг гүйцэтгэж бэлэн бус торгуулийн арга хэмжээ авч, Жолооч нарт хурд тохируулж явах, хамгаалах бүс тогтмол зүүх дээр санамж сэрэмжүүлэг 500 ш боршур тараан ажиллаж байна. Цаашид: Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд тодорхой ажил арга хэмжээг үе шаттайгаар зохион | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байгуулан ажиллах болно. Мөн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хурд хэмжигчтэй болоод байна. | | |
| 52 | 59 | Журам батлах тухай<br>2017.01.02 №31<br>Засгийн газрын 2017 оны 31 дүгээр тогтоолын хавсралт<br>Хоёр. Насны хишиг авах ахмад настны хүсэлтийг хүлээн авах, хянан шийдвэрлэх | 2023 оны эхний хагас жилийн байдлаар 65-69 настай 63 ахмадад 3150,000 төгрөг, 70-79 настай 70 ахмадад 5,600,000 төгрөг, 80-89 настай 36 ахмадад 5,400,000 төгрөг, 90-ээс дээш настай 3 ахмадад 750,000 төгрөгийг олгож ажиллалаа. | 100 | |
| 53 | 60 | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2016.01.04 №15<br>1.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллан, татварын нэгдсэн системд холбогдох;<br>1.2. бараа, ажил, үйлчилгээг худалдан авах болон борлуулах тухай бүрт төлбөрийн баримт хэрэглэж, үүнийг хэвшүүлэх;<br>1.3. иргэд, хуулийн этгээдэд төлбөрийн баримт хэрэглэх үйл ажиллагааг хэвшүүлэх талаар нийтэд сурталчлан таниулах. | 2023 оны хагас жилийн байдлаар суманд үйл ажиллагаа явуулж байгаа 7-н Аж Ахуй Нэгж, 5-н Аж Ахуй Эрхлэгчид НӨАТатварын тухай хууль, НӨАТУС-ийн талаар Монгол улсын Сангийн сайдын 2017 оны 12-р сарын 5-ний 347 дугаар тушаалыг үндэслэн ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж ажиллалаа.<br>Төлбөрийн баримтыг хэрхэн албан байгууллагын анхан шатны баримт болгон ашиглах талаах Аж ахуй нэгжүүдэд мэдээлэл хийв. Энэ онд Баян үйлст хайрхан ХХК, Эрч хүч ХХК, Эмийн эргэлтийн сан, Мөнхцагаан толгой ХХК, Гурван тулгат цагаан хайрхан ХХК, Гурван баян загал ХХК, Бүтэн заяа ХХК, Алтан жолоот хүлэг ХХК зэрэг Аж ахуй нэгжүүд нь сумын иргэдэд цахим төлбөрийн баримт болох E-barimt-ыг олгож байна. Засаг даргын тамгын газар, Сум дундын эмнэлэг, ерөнхий боловсролын сургуульд зэрэг албан байгууллагуудад НӨАТ ,НӨАТУС-ийн талаар сургалт хийж Ebarimt-ыг хэрэн бүртгэх, урамшуулалыг хэрхэн тооцох, гар утаснаас 131313 дугаарт бар код үнийн дүнг илгээх, ухаалаг утсанд Аппликейшин суулгах зэрэг мэдээлэлийг хүргэж ажиллалаа. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа 8-н Аж Ахуй Нэгж, НӨАТУС-ийн талаар Монгол улсын Сангийн сайдын 2017 оны 12-р сарын 5-ний 347 дугаар тушаалыг үндэслэн ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж ажиллалаа. | 70 | |
| 54 | 61 | Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги батлах тухай 2015.08. 31 №353<br>3. Үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэнд, спортын сайд, | Эмнэлгийн 27 эмч мэргэжилтнүүдэд "Давсны зөв хэрэглээ", "Давсыг юугаар орлуулж болох вэ?" сэдвээр дотоодын сургалтыг 4 удаа зохион байгуулж , сургалтын өмнө ба дараа хүний хоногт хэрэглэх давсны хэмжээ хэд байх талаар мэдэг сорих асуултанд сургалтын өмнө 47,5, сургалтын дараа 91, болж өссөн байлаа. Мөн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан Сумын ИТХ-хамтран Хүнсний худалдаа үйлчилгээ явуулдаг болон , гал тогоо бүхий 7 | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Сангийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | үйлчилгээний байгууллагад 60 ширхэг зөвлөмж бэлтгэн хүргүүлж, үйлчилгээний байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2018 оны 01 сарын 23-ний өдрийн А/16 тоот тушаалын дагуу хоолны цэс, хоолны технологийн картыг батлаж, хоол эмчилгээний зохион байгуулалт, холбогдох дүрэм, заавар, стандартыг мөрдөж эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгч нарт "давсны зөв зохистой" хоолоор хангаад байна. Эрүүл мэндийн төвийн Тогооч хэвтэн эмчлүүлэг нарт "Давсны хэрэглээг бууруулах" сургалтыг 7 хоног болгон хийж гэрэл зураг болон гарын үсгээр баталгаажуулж ажиллаж байна. | | |
| 55 | 62 | Журам, жагсаалт шинэчлэн болон шинээр батлах тухай<br>2013.03.22 №106<br>2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраахад шаардлагатай техник, багаж хэрэгслийг худалдан авахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гамшиг осол гарсан үед журмын дагуу хөрөнгө зарцуулан ажиллаж байна. Тус сумын 1,2,3,4-р багийн иргэдийн нийтийн хурал дээр ой хээрийн түймэр түүнээс урдчилан сэргийлэх ба хаана мэдэгдэх, гарч болзошгүй цаг хугацаа байгалийн хүчин зүйл буюу цаг агаар, авч болох өөрсдийн боломжит арга хэмжээ, сумын онцгой комиссын бүрэлдэхүүн гэх мэт мэдээ мэдээлэл, сурталчилгааг хийж багийн засаг дарга нарт үүрэг чиглэл өглөө. 2023 оны хагас жилийн байдлаар Байгаль орчны тухай хуулиуд журмын зөрчил гэмт хэргийг бууруулах зорилгоор Байгаль орчны хяналт шалгалтыг Цагдаагийн байгууллага төрийн албан хаагчтай хамтран хяналт шалгалтыг 5 удаа хийж гүйцэтгэлээ. | 100 | |
| 56 | 63 | Нийтлэг журам батлах тухай.<br>2011.11.09 №311<br>1. "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2 8.2.1-д заасны дагуу харьяа байгууллага, аж ахуйн нэгж, өөрийн аппаратад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан | Албан байгууллага бүрт дотоод хяналтын багтай болж байгууллагын дарга нарын тушаалаар баталгаажуулан жил бүр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж биелэлтийг нь ханган ажиллаж байна. Сумын зүгээс дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үүднээс хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 70 | |
| 57 | 64 | Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай.<br>2009.05.14 №143<br>2. "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын | Төсвийн бүх байгууллага ил тод байдлыг журмын дагуу биелэлтийг хангаг ажиллаж байна. Байгууллага бүр ил тод байдлын самбар ажиллуулж байна. Төрийн сан төсвийн мэдээ тайланг тогтмол шилэн дансанд байршуулан ажилласан. Засаг даргын Тамгын газрын Esunzuil ZDTGazar | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай | facebook хаяг, Есөнзүйл сум ЗДТГ, Ysunzuil ЕМТ, Есөнзүйл сумын ЕБС, Есөнзүйл цэцэрлэг зэрэг цахим хуудсуудаар цаг үеийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй иргэдэд хүргэж ажиллаж байна. | | |
| 58 | 65 | "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2009.04.01 №93<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:<br>1. Тендерийн урилга, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд (www.e-procurement.mn) цаг хугацаанд нь бүрэн тавьж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг нээлттэй, ил тод мэдээлж байх | Тендерийн урилга үр дүнг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдөрт багтаан Засаг даргаар батлуулж www.tender.gov.mn цахим хаягт тендерийн ерөнхий төлөвлөгөө, урилга, үр дүнг тогтмол байршуулан ажиллаж байна. Мөн www.shilendans.gov.mn цахим хаягт мэдээллэж ажиллалаа. | 100 | |
| | 66 | 2. Захиалагч бүр жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аливаа хяналт, аудитын тайлан, дүгнэлт, иргэд болон байгууллагаас гаргасан гомдлын тоо, агуулга, шийдвэрлэсэн байдлын талаар байгууллагын самбарт нийтэлж, нийтэд ил тод хүргэж байх | Тендерийн ерөнхий төлөвлөгөөг Засаг даргаар батлуулж www.tender.gov.mn цахим хаягт оруулж яамаар батлуулан ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангийн баримт болон ажилд хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээллийг шилэн данс болон мэдээллийн самбар, сумын вэб сайт, сэтгүүлд байршуулан ил тод байдлыг хангаж ажиллаж байна | 100 | |
| | 67 | 3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажилтнуудын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх болон худалдан авах ажиллагааны чиглэлээрх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж байсугай. | Төрийн албан хаагчдын худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх үүднээс Худалдан авах ажиллагаа явуулах А3 сертификатгүй төрийн албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээнд А3 сертификаттай болох заалтыг оруулж өгч ажиллан. 2023 оны хагас жилийн байдлаар сумын хэмжээнд А3 сертификаттай 12 төрийн албан хаагч 1 иргэн байна. | 100 | |
| | 68 | 4. Харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ хууль зөрчиж байгаа нийтлэг дутагдлыг арилгаж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босгон үнээс дээш өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулж байх | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж байна. 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 27 ажил байгаагаас журмын дагуу харьцуулалтын аргаар 6 ажил, зөвлөх үйлчилгээний аргаар 1, шууд гэрээ байгуулах 20 ажил төлөвлөгөөний дагуу тендерүүд зарлагдаж эхний улиралд 11 ажил гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 69 | 5. Захиалагч бүр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллан, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай бүрт мөн хуулийн 49.2-т заасан баримт бичиг, материалыг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалж байсугай. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн баримт бичигийг Засаг даргын Тамгын газрын архивт хүлээн авч архивийн нэгж үүсгэн данс бүртгэлд оруулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан бүх тендерийг зарлан ажлыг гүйцэтгүүлэн ажилласан. 2023 оны эхний хагас жилд 11 ажлыг зарлан гэрээ байгуулан хуулийн 49.2 дахь заалтын дагуу архивлаад байна. | 100 | | |
| 59 | 70 | Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай /Үдийн цай/ 2006.08.16 №19<br>Үдийн цай" хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлэх ажлыг чанартай зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд, үдийн цайнд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, орчны ариун цэврийн талаар тогтмол хяналт тавих ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд У.Хүрэлсүхэд тус тус даалгасугай | Ерөнхий боловсролын сургууль Үдийн цай хөтөлбөрийн хувьд дараах ажлыг хийж хэрэгжүүллээ.<br>- 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 9 бүлгийн нийт 197 суралцагч үдийн хоол хөтөлбөрт хамрагдаад байна. Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт тавих орон тооны бус хяналтын нэгж нь дотоод хяналтын нэгжтэй хамтран үдийн хоолны үйл ажиллагаатай танилцан эрүүл ахуй,халдвар хамгааллын дэглэм хэрхэн баримтлан ажиллаж буйд үнэлгээ дүгнэлт өгч ажиллалаа.<br>- Боловсролын салбарын нэгдсэн мэдээллийн систем дэх "Хоол бүртгэлийн систем" хэсэгт үдийн хоолны цэсний дэлгэрэнгүй тайлан , анги удирдсан багш нарын өдөр тутмын ирцийн бүртгэл, тогооч нарын хоолны мэдээллээ өдөр тутам бүрэн гүйцэд оруулж буйд хяналт тавьж хяналтын хуудсыг 7 хоног бүрээр татан авч хяналт тавьж ажиллалаа.<br>- Боловсролын мэдээллийн нэгдсэн системээс хоолны цэс болон бүлэг хамрагдалт, гүйцэтгэлийн тайлан /хоол орц, илчлэг шимт бодис, ирц/, хоолны хяналтын хуудас хэсгээс тогооч мэдээлэл оруулсан эсэх, хамрагдсан сурагчийн тоо, мэдээлэл оруулсан хугацаа, хоолны нэр, хоолны зураг, эцэг эхийн дундаж үнэлгээ, эцэг эхийн сэтгэгдлийн тоо зэрэг үзүүлэлт тус бүрд 7 хоног тутамд хяналт тавьж ажиллалаа.<br>- Анги танхим болон бага сургуулийн гал тогооны эрүүл ахуй ,халдвар хамгааллын дэглэм баримтлах, хувийн эрүүл мэндийг хамгаалах талаар эрүүл мэнд,онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн заавар зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.<br>- Сургуулийн орчинд үдийн хоолноос хамааралтай хоол хүнсний хордлого гарахаас урьдчилан сэргийлэх замаар хяналтын зөвлөл болон дотоод хяналтын үйл | 100 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагаат сайжруулах, үдийн хоолонд өгөх бүтээгдэхүүнд шим тэжээллэг ,амин дэмээр баялаг хоол хүнсний бүтээгдэхүүнийг сонгон өгч байна.<br>- Анги удирдсан багш нар болон жижүүр багш, Shool police-ийн эргүүл жижүүр хийж байгаа эцэг эхчүүд өдөр тутмын хоолны амт чанарт хяналт тавьж тэмдэглэл хөтлөн ажиллаж хэвшсэн.<br>- Суралцагчид үдийн хоолны аяга халбага болон үдийн хоолны хэрэгс-лийнхээ болон хувийн ариун цэврийг өдөр тутам сахих, анги танхимдаа хүнсний бүтээгдэхүүн дамжуулж хэрэглэхгүй байх талаар анги удирдсан багш нар болон суралцагчдад мэдээлэл өгч ажиллалаа.<br>- Хүнсний бүтээгдэхүүн хадгалах складанд цэвэрлэгээ халдваргүйжүү-лэлтийг СДЭ- ийн заавар зөвлөмжийн дагуу сард 2 удаа хийж бараа бүтээгдэхүүнийг ангилан төрөлжүүлж хадгалалтын горимыг баримтлан ажиллаж байна.<br>- Сурагчдын бие бялдрын хөгжил болон улирлын томуу болон томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчдын үдийн цайнд халуун аарц, сүү, үзэмний шүүс болон чацарганы шүүс гурилан бүтээгдэхүүн зэргээр байнга үйлчлэн долоо хоногийн 3 өдөр халуун хоол,цай, 2 өдөр цагаан хоол,аарц болон чацарганы шүүс өгч байна.<br>- Анги удирдсан багш ангийн сурагчдын бие бялдрын өсөлт хөгжлийг улирал тутам гаргаж биеийн жингийн индексийг өмнөх улиралтай нь харьцуулан өсөлт хөгжлийн судалгааг гарган ажиллаж байна.<br>- Хүнсний бүтээгдэхүүн хадгалах складыг тохижуулан бараа бүтээгдэхүүнийг ангилан төрөлжүүлж хадгалалтын горим болон халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байна.<br>- Мөн үдийн хоол хөтөлбөрт бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх тендер зарласны дагуу Алтанжолоот хүлэг ХХК шалгаран гэрээ байгуулан 7-14 хоног тутамд хүнсний бүтээгдэхүү-нийг баталгааны бичиг, шинжилгээ, гарал үүслийн бичигтэй бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж байна.<br>Хүнсний бүтээгдэхүүн хадгалах складанд цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг СДЭ- ийн заавар зөвлөмжийн дагуу сард 2 удаа хийж бараа бүтээгдэхүүнийг ангилан төрөлжүүлж хадгалалтын горимыг баримтлан ажиллаж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | - Сурагчдын бие бялдрын хөгжил болон улирлын томуу болон томуу тест өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчдын үдийн цайнд халуун аарц, сүү, үзэмний шүүс болон чацарганы шүүс гурилан бүтээгдэхүүн зэргээр байнга үйлчлэн долоо хоногийн 3 өдөр халуун хоол,цай, 2 өдөр цагаан хоол,аарц болон чацарганы шүүс өгч байна<br>-Эрүүл мэндийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 04 ний өдрийн 207дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасан "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан хоол үйлчилгээнд хориглох хоол, хүнсний түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн"-ий жагсаалтыг гаргаж 1-5 ангийн анги удирдсан багш ,нярав,тогооч нарт танилцуулж сурталчилсан.<br>-Сургуулийн нярав нь үдийн хоолны цэсийг тогооч нартай хамтран 7 хоног тутамд боловсролын мэдээллийн нэгдсэн ситемд хоолны хуваарийг оруулан цэсийн дагуу сурагчдад халуун хоол цай болон бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилж байна.<br>- Долоо хоног бүрийн Баасан гарагт хичээлийн байр, гал тогоо болон анги танхимд их цэвэрлэгээ хийж ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж хэвшсэн.<br>- Үдийн хоолны дээж бүртгэлийг тогтмол хөтлөх, устгал хийх үйл ажиллгааг тогтмол хийж, хөтөлж хэвшсэн. | | |
| 60 | 71 | Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай 2005.04.01 №67<br>1.б. Иргэдээс амаар бичгээр болон цахим сүлжээ, радио телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр түүнчлэн тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг шалгах, шийдвэрлэлтийн явцыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг нийтэд зарлан сурталчилах зэрэг ажлыг дээрх журамд тусган хэрэгжүүлэх | Есөнзүйл суманд 2023 оны 02 дугаар улирлын байдлаар нийт 161 өргөдөл хүлээж авсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 305 өргөдөл хүлээн авч бүх өргөдлийг 100% шийдвэрлэж ажилласан байна. Ирүүлсэн нийт өргөдлүүд 100% бичгээр ирсэн бөгөөд бүртгэл хяналтын карт үүсгэн шийдвэрлэх ёстой хугацаанд нь шийдвэрлэж ажилласан байна. Засаг даргын Тамгын газарт нийт 299 өргөдөл ирсэнээс хамгийн их буюу нийгмийн халамжтай холбоотой 132 ирүүлсэн буюу нийт өргөдлийн 43,3%-г эзэлж байна. Эхний хагас жилийн хувьд халамжтай холбоотой өргөдөл 132, газар өмчлөх тухай хүсэлт, өвөлжөө хаваржааны газар хүссэн өргөдөл нийт 5, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах талаарх өргөдөл 58, ажилд орох, чөлөөлүүлэхтэй холбоотой өргөдөл 10, нийгмийн даатгалтай холбоотой 12, тэтгэвэр тогтоолгох 21, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 0, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 46, Материал мөнгөн тусламж хүссэн 3, бусад чиглэлээр ирүүлсэн 18 өргөдөл тус тус ирж шийдвэрлэн ажилласан байна. Сумын | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | албан байгууллагуудаас Эрүүл мэндийн төвд ажилд орох гарахтай холбоотой 3 өргөдөл, Ерөнхий боловсролын сургуульд ажилд орохтой холбоотой 1, Соёлын төвд ажилд орохтой холбоотой 1, чөлөө хүссэн 1 өргөдөл ирүүлэн 100% шийдвэрлэсэн байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, эхний хагас жилийн байдлаар өргөдөл гомдол ирүүлээгүй байна. Байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг бэлтгэсэн маягтын дагуу цахим болон цаасаар баталгаажуулан авч ажиллаж байна. Албан байгууллага болон өргөдөл гомдол хүлээн авч буй албан хаагчдад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн дагуу өргөдөл хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөө өгөн ажиллаж байна. | | |
| 61 | 72 | Ногоон хэрэм дэд хөтөлбөр 2005.03.09<br>Дугаар 44<br>Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж ойн сан хомсдох, цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуурга улам эрчимжиж байгаа экологийн өнөөгийн сөрөг нөлөөллийг багасгаж, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгоход байгаль орчин, нийгэм эдийн засгийн хөгжлийн цогц бодлого, арга хэмжээг бүс нутгийн онцлогт тохируулан урт хугацааны турш үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол орны говь, хээрийн бүсийн заагийг бүрэн хамарсан ногоон зурвас, ногоон төгөл байгуулахад оршино. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд засмал зам дагуу 10 га газарт улиас, хайлаас, бургас төрлийн 20000 мод, бут тарьсан тарьлаа. Мөн Дэлгэөн уулын гацааны аманд 50ш улиасыг хашаалж тарих ажлыг зохион байгууллаа. Сумын төвийн хойд талд хашаалсан талбайд 2000 бургас, хайлаас, улиасны төрлийн модыг тарьлаа. Аж ахуй нэгж албан байгууллага 1200 ширхэг модыг өөрсдийн албан байгууллагын талбайг хашаажуулан хамгаалалт хийн тарьлаа.<br><br>Бүх нийтээр мод тарих хөдөлгөөнийг зохион байгуулж сумыньөвийн албан байгууллага, аж ахуй нэгж, иргэд нийт 2500 модыг сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд тарих ажлыг хийж гүйцэтгэлээ. Нийтээр мод тарих өдрүүдэд 2022 болон урд жилүүдэд тарьсан мод бутыг услах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | | |
| Хэсгийн дундаж 91,3 хувь. | | | | | |
| **Тав.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 62 | 73 | 2022 оны 2 дугаар сарын 9-ний өдөр 9 дүгээр тэмдэглэл 2022-02-09 Дугаар №99<br>Ү.5.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс шинээр эхлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, орон нутагт эрх нь шилжсэн худалдан авах ажиллагааг яаралтай зохион байгуулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; | Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллаж байна. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 63 | 74 | 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугээр тэмдэглэл 2022-03-16 Дугаар №16<br>ХҮ111.13.Орон нутаг дахь боловсролын байгууллагын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг 2022 оны төсвийн жилээс эхлэн орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлж эхэлсэнтэй холбогдуулан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын хэмжээнд төсвийн зохицуулалт хийх арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгов. | Ерөнхий боловсролын сургуулийн 80 хүүхдийн ортой дотуур байрны их засварийг 2023 онд хийхээр төлөвлөн ажиллаж байна. | - | |
| 64 | 75 | 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 49 дүгээр тэмдэглэл 2021-08-31 Дугаар 2021_49<br>Х111.5.2.Төрийн болон орон нутгийн музейн харуул хамгаалалтын чиг үүргийг гүйцэтгэхэд мөрдөх аргачлал, зааварчилгааг хамтран баталж мөрдүүлэх, харуул хамгаалалтын ажилтны ур чадварыг дээшлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;<br>Х111.5.4.Харьяалах нутаг дэвсгэр дэх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Соёлын өвийн гэрээт харуулуудаас хагас жилийн тайланг бичгээр болон фото зураг хэлбэрээр авч ажиллаа. Шинээр бүртгэсэн соёлын өв болон өв хамгаалагч нар байхгүй. Улсын тооллогыг хийж гүйцэтгэх бэлтгэл ажлыг хийж явах газрын маршрутыг гарган ажиллаа. Орон нутаг судлах танхим буюу "Бурхан бумбын орон" уран зургийн галарейгаар үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн тоо хагас жилийн байдлаар 220 гаруй хүнд үйлчилсэн байна. | 70 | |
| **Хэсгийн дундаж 85 хувь.** | | | | | |
| **Зургаа.Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 65 | 76 | Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017.10.26 №01<br>Шударга ил тод хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг өгч байна.<br>Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд | Төрийн албан хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүйн зөрчилгүй ажиллах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх талаар, тодорхой заалтыг тусгуулан хэрэгжилтийг нь хагас жилээр дүгнэн ажиллаж байна. Мөн төрийн албан хаагч бүрээр Төрийн албаны манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, төрийн хууль ёсыг чанд сахин аймаг орон нутгийнхаа хөгжлийн төлөө эрдэм чадлаа зориулж, өөрийн болон байгууллага, хамт олныхоо нэр төр, соёлч байдлыг эрхэмлэн иргэдийг ялгаварлахгүйгээр ижил тэгш, зөв шударга харьцаж, ажлын цагийг цалгардуулж хийдүүлэхгүй, | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах. | бүтээмжээ нэмэгдүүлж, аливаа хууль бус дарамт шахалтад автахгүй, үйлдэхгүй, албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байхаа илэрхийлж баталгаа гаргуулан аваад байна.Есөнзүйл сумын эрүүл мэндийн төв нь 2023 оны эхний 6 сарын байдлаар 1 албан хаагч удаа дараа ажлыг хариуцлага алдсанаар сахилгын шийтгэл ногдуулсан байна. | | |
| | 77 | 2.Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх | Есөнзүйл сумын Авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх эрх бүхий албан тушаалтныг шинээр томилогдсон тохиолдолд хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлэгийг 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газар хүргүүлэн ажиллаж байна. 2023 оны хагас жилийн байдлаар 4 албан хаагчийн мэдүүлгийг хүргүүлээд байна. | 100 | |
| | 78 | 3.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах | Есөнзүйл суманд 2023 оны 02 дугаар улирлын байдлаар нийт 161 өргөдөл хүлээж авсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 305 өргөдөл хүлээн авч бүх өргөдлийг 100% шийдвэрлэж ажилласан байна. Ирүүлсэн нийт өргөдлүүд 100% бичгээр ирсэн бөгөөд бүртгэл хяналтын карт үүсгэн шийдвэрлэх ёстой хугацаанд нь шийдвэрлэж ажилласан байна. Засаг даргын Тамгын газарт нийт 299 өргөдөл ирсэнээс хамгийн их буюу нийгмийн халамжтай холбоотой 132 ирүүлсэн буюу нийт өргөдлийн 43,3%-г эзэлж байна. Эхний хагас жилийн хувьд халамжтай холбоотой өргөдөл 132, газар өмчлөх тухай хүсэлт, өвөлжөө хаваржааны газар хүссэн өргөдөл нийт 5, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах талаарх өргөдөл 58, ажилд орох, чөлөөлүүлэхтэй холбоотой өргөдөл 10, нийгмийн даатгалтай холбоотой 12, тэтгэвэр тогтоолгох 21, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 0, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 46, Материал мөнгөн тусламж хүссэн 3, бусад чиглэлээр ирүүлсэн 18 өргөдөл тус тус ирж шийдвэрлэн ажилласан байна. | 100 | |
| | 79 | 4.Ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих | Ажлын цагаар төрийн албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэх, үүрэгт ажлаа чанартай сайн гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж бусад хувь хүн өөрийн хөгжих талаас нь үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд ажлын байран дээр олон нийтийн | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | цахим сүлжээг ашиглахгүй байх дэг журмыг өөрдсийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | | |
| | 80 | 5.Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх | Төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар байгууллагын дотоод журманд тодорхой заалтуудыг оруулан биелэлтийг нь хангаан ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд Тухайн сургууль нь 100% мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан ба хамгийн багадаа 4 дэх жилдээ ажиллаж байгаа багш, ажиллагсад байгаа бөгөөд төрийн албан хаагчдыг тогтвор, суурьшилттай ажиллах нөхцөл боломжоор хангаан ажиллаж байна. Мөн Соёлын төв, Эрүүл мэндийн төвүүд мэргэжлийн шаардлага хангасан албан хаагчдыг хууль тогтоомжийн дагуу ажиллуулан үйл ажиллагаа явуул байна. | 100 | |
| | 81 | 6.Албан тушаалтны сахилга. хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах | Албан тушаалтан бүрээр сахилга, хариуцлагыг чангатгах, өндөржүүлэх талаар баталгаа гаргуулж уриалгад нэгдүүлэн ажиллаж байна. Мөн Удирдах ажилтаны улсын зөвлөгөөнөөс гарсан андгайг албан хаагч бүрээр өргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.Тухайн албан байгуууллага бүр дотоод хяналтын нэгж нь улирал бүр байгууллагын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж гарсан алдаа дутагдал бүрийг цаг тухайд нь засч залруулан үйл ажиллагааны гүйцэтгэл, чанарт ахиц гарган ажиллаж байна. Байгууллагын дотоод хяналтын нэгж нь улирал бүр тайлан мэдээг хүргүүлэн үнэлгээ дүгнэлт авч ажиллаж байна. | 100 | |
| | 82 | 7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах | 2023 оны Худалдан авах ажиллагааны Ерөнхий төлөвлөгөөг боловсруулж төлөвлөгөөнд тусгагдсан ажилуудын тендерийг зарлаж ажлыг гүйцэтгэж байна.<br>1.Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод нээлттэй зохион байгуулж, бүх худалдан авалтыг цахим тендер шалгаруулалтаар зохион байгуулж, дотоод давуу эрхийг тооцож ажилласан.<br>2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний болон төсөвт байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудасд тогтмол байршуулж тендерийн явц үр дүн, гүйцэтгэлийн мэдээ, мэдээллийг тухай | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээллэж ажилласан.<br>3. Худалдан авах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээний хороонд Сумын Иргэдийн Төлөөлөгчдын Хурлаас томилсон иргэний төлөөллийг тухай бүрд нь үнэлгээний хороонд оруулж ажилласан<br>4. Төсөвт байгууллагуудын өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем дэх хөрөнгийн бүртгэл мэдээлэл бүрэн хийгдэж, зургийг оруулах ажил хийгдэж байна.<br>5. Орон нутгийн өмчид байгууллагуудын газар эзэмших эрх нь тухайн байгууллагын хөрөнгөд бүртгэж ажилласан<br>6.Тендерийн ерөнхий төлөвлөгөөг Засаг даргаар батлуулж www.tender.gov.mn-д оруулж яамаар батлуулан ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангийн баримт болон ажилд хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээллийг шилэн данс болон мэдээллийн самбар, сумын вэб сайтанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна. | | |
| | 83 | 8.Төрийн албаны тухай хууль тогтоомж. дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх; | Төрийн албан хаагчийн ажлын хийдэлийг арилгах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүрийн үр дүнгийн гэрээ байгуулахад нь онцгой анхаарал тавин ажиллаж байна. Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээнд төрийн албан хаагчийн ур чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг тусган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн өөр өөрийн онцлогт нь тусган мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилтуудыг жил бүр харилцан тохирч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган биелэлтийг нь тооцон ажиллаж байна. Төрийн албан хаагчдыг дээд байгууллагаас зохион байгуулж буй цахим сургалт семинарт 100% хамруулан үр дүнг бий болгон ажиллаж байна | 70 | |
| | 84 | 10.Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах. | Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэн ажиллаж байна. Өндөр дүгнэгдсэн албан хаагчийг хууль ёсны дагуу урамшууллыг олгон ажиллаж байна. Мөн албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл чанарт үнэлэлт дүгнэлт өгч ажлын чанар, гүйцэтгэлийн хувиар улирал бүр мөнгөн урамшуулал олгож байна | 70 | |
| | 85 | 11.Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, | Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж хэмнэлтийн горимыг чанд сахин төлөвлөгөөний дагуу захиран зарцуулж ажиллаж байна. 2022 оны 04 дүгээр сарын 29-ны | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна | өдөр батлагдсан Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн мөрдлөг болгон ажиллаж байна. | | |
| | 86 | 12.Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж байна. | Сумын хэмжээнд төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх үүднээс суманд иргэний танхим, нэг цонхны үйлчилгээг байгуулж иргэдэд төрийн үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100 | |
| **Хэсгийн дундаж 91,8 хувь.** | | | | | |
| **Нийт дундаж 94,6 хувь** | | | | | |

ХЯНАСАН: ЕСӨНБҮЙЛ СУМЫН ОРЛОГЧ
ДАРГА Ч.ГАНХҮҮ

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ